

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Сэдэв: "Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах"

Хаана: Төрийн ордны "Үндсэн хууль" танхимд 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 14:00 цагаас эхэллээ.

Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Б.Жаргалмаа нээж, сонсгол зохион байгуулах болсон үндэслэл, сонсголын зорилго, оролцогчдын ирц, сонсголын дэг, дараалал, сонсголд оролцогчдын эрх, үүргийг танилцууллаа.

Б.Жаргалмаа - Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголд оролцогч Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Сонсголд оролцогчдын ирц бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Хяналтын сонсголыг нээснийг мэдэгдье.

Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан сонсгол болон Улсын Их Хурлаас зохион байгуулах ерөнхий хяналтын, төсвийн хяналтын, нэр дэвшигчийн, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой сонсголд тухайн асуудал эрхэлсэн Байнгын, дэд, түр хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцох бөгөөд уг шаардлагыг хангаагүй зохион байгуулсан сонсголыг хүчингүйд тооцно" гэж заасан байдаг.

Нийгмийн бодлогын байнгын хороо нийтдээ 17 гишүүнтэй, 17 гишүүнээс нийтдээ 6 гишүүн ирсэн учир ирц бүрдсэнд тооцон, ийнхүү сонсголыг эхлүүлж байна. Сонсголын зорилго дэгийг Та бүхэндээ танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан нарын 9 гишүүнээс Хүүхдийн эрхийн тухай хуульд заасны дагуу хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрх, Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, хувийн мэдээлэл, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үр нөлөөг сайжруулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэдээлэл авах, үнэлэх зорилгоор хяналтын сонсгол явуулах хүсэлт ирүүлсний дагуу Байнгын хороо өнөөдрийн хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг зохион байгуулж байна.

Ингээд сонсголд оролцогчдын мэдээлэл хийх, хуралдааны дэгийн дарааллыг та бүхэндээ танилцуулъя.

Сонсголд оролцож буй Улсын Их Хурлын гишүүд асуулт асуух бөгөөд 20 минутад багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно.

Сонсголтой холбогдуулан асуулт асуухаар бүртгүүлсэн оролцогчдын асуултыг сонсгол даргалагч төлөөлөн асууна. Сонсголд оролцож байгаа Улсын Их Хурлын гишүүд 5 минутад багтаан үг хэлнэ. Сонсголд үг хэлэхээр урьдчилан бүртгүүлсэн оролцогчид 5 минутад багтаан саналаа танилцуулна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Х.Хунан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газраас тус тус мэдээлэл хийнэ.

Сонсголд:

- Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг холбогдох төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд;
- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн судлаачид оролцогчид;
- Монголын сургуулийн нийгмийн ажилтны холбоо, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төлөө Галт шувуу холбоо, Өсвөр үеийнхний хөгжлийн төв, Саран ээж нийгэмлэг, Манай гэр асрах төв зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөл болон иргэдийн төлөөлөл, ажиглагч;
- Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, parliament.mn зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл нийт 50 гаруй оролцогчид оролцож байна.

Нэгдүгээрт Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид “ХЭҮК”-гэх)-ын дарга Х.Хунан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26.4 дэх хэсэгт заасны дагуу хуулийн хэрэгжилтийн дүгнэлтийг танилцуулах байгаа. Ингээд Х.Хунан даргыг урья.

Х.Хунан - Эрхэм Улсын Их Хурлын гишүүд болон хүрэлцэн ирсэн зочдод энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Өнөөдрийн энэ сонсгол явагдаж байгаад их баяртай байна. ХЭҮК-оос хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр ямар ажил хийсэн, ямар бодлого барьж байгаа, ямар ажлууд төлөвлөж байгаа талаар мэдээллийг өгье.

ХЭҮК нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш хүүхдийн эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулж ач холбогдол өгч ажиллаж ирсэн. Үүнийг Улсын Их Хуралд өргөн барьсан Хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлийн агуулга сэдвээс харж болно. Нийтдээ 22 удаа Улсын Их Хуралд хүний эрх эрх чөлөөний талаарх илтгэлийг өргөн барьснаас 16 удаагийнх нь илтгэлд хүүхдийн эрхийн тулгамдсан асуудлуудыг тусгаж ирсэн. Ямар, ямар эрхийн хүрээнд, ямар асуудлуудыг хөндсөн талаар та бүхэнд товч танилцуулъя.

Юуны өмнө хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг нийтдээ 7 удаагийн илтгэлд оруулж, хэлний цөөнх, хүүхдийн сурч боловсрох эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн асуудлуудыг хөндөж байсан.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалтай холбоотой 2 удаагийн илтгэлд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хөндөж илтгэлдээ оруулж байсан.

Мөн гэр бүлийн хүчирхийллээс ангид байх эрхийн хүрээнд 4 удаагийн илтгэлд гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийн зарим асуудал хамтарсан багийн чиг үүрэг, үйл ажиллагаа, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн асуудлыг хөндөж оруулж байсан.

Хүүхдийн эрхийн зарим асуудлын хүрээнд нийтдээ 6 асуудлыг хөндсөн. Энэ хүрээнд бол хүүхдийн эрхийн төлөв байдлыг ерөнхийд нь авч оруулж байсан. Сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүдийн эрхийн асуудлыг оруулж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн асуудлыг хөндөж байсан.

Хурдан морь унаач хүүхдүүдийн асуудлыг хөндөж илтгэлдээ тусгаж байсан. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр дахь хүүхдийн эрхийн асуудлыг хөндсөн.

Мөн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаатай холбоотой хүүхдийн эрхийн асуудлуудыг илтгэлдээ оруулж, хөндөж, хүүхдийн эрхийн асуудлаар мэдээллийг гаргаж байсан.

2020-2023 оны хооронд үндсэндээ бол ХЭҮК-ын тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, шинэ бүрэлдэхүүн томилогдсоноос хойш ХЭҮК-т нийтдээ хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 385 гомдол ирсэн байдаг. 172 хяналт шалгалтыг зохион байгуулж, ХЭҮК-ын зөвлөмж 8 удаа хүүхдийн эрхийг хангах хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудад хүргүүлж байсан. Хүүхдийн эрхийг хангах хамгаалах чиглэлээр ХЭҮК-ын гишүүний 21 зөвлөмж хүргэгдэж байсан. Мөн 11 шаардлага нь энэ хүүхдийн эрхийн зөрчлийг таслан зогсоох хамгаалах чиглэлээр байсан байна. Комисст ирж байгаа гомдлыг ангилж төрөлжүүлж харвал хүүхдийн эрхтэй холбоотой гомдол 2020 онд 17, 2021 онд 50, 2022 онд 61, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 38 гомдол ирсэн байна. Эндээс бид нар юу гэж харж болох вэ гэвэл, сүүлийн 3 жилийн хугацаанд хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой гомдол бол тогтмол нэмэгдэж байгаа дүр зураг харагдаж байна.

Гомдлуудыг гаргасан асуудлаар нь авч үзвэл сүүлийн нэг жилд хүүхдийн мөнгөтэй холбоотой, хүүхдийг ялгаварлан гадуурхсан хүүхдийн мөнгийг ялгавар, ялгамжтай олгож байгаа, бага насны хүүхэд бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон талаарх, хүүхдийн хөдөлмөртэй холбоотой өөрөөр хэлбэл хүүхдийг хүчээр хөдөлмөр эрхлүүлж байгаа талаарх, хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөж байгаа, хүүхдийн сурч боловсрох эрх сургуулийн орчинд болон дотуур байрны орчинд зөрчигдөж байгаа гэдэг ийм гомдол байна.

Хүүхдийн тэтгэмж төлөгдөхгүй байгаа өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэрээр хүүхдийн тэтгэмж ... /микрофон хаагдсан/

Б.Жаргалмаа - Х.Хунан даргаа бид дэгээр явах ёстой 5 минутад багтаах ёстой. Тэгэхээр та илгэлээ товчлоод зөвхөн яг хүүхэд хамгаалуулах эрх хэрхэн зөрчигдөж байгаа тухай, энэ талаар авсан арга хэмжээгээ товчхон ярих уу?

Х.Хунан - За цаг бага учраас товчхон явъя. Үндсэндээ бол сүүлийн 2 жилийн хугацаанд ХЭҮК хүүхдийн эрхийн тодорхой асуудлуудыг өөрөөр хэлбэл хүүхэд хамгаалуулах эрхийн хүрээнд хамтарсан багийн үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээ, хамгаалах байрны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байгаа. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд хяналт шалгалт хийж Улсын Их Хуралд өргөн барьсан.

ХЭҮК-оос ямар дүгнэлт хийж байна вэ гэвэл, өнөөдөр хүүхэд орхигдсон. Хүүхэд хамгаалуулах эрх нь зөрчигдөж байгаа, хүүхэд хамгаалах энэ тогтолцоо ажиллахгүй байна, үр дүнгүй байна. Энийг яаралтай өөрчлөх шаардлагатай гэдэг дүгнэлтийг хийсэн байгаа.

Мөн энэ 2 хүүхэд хамгааллын чухал бүтцээс гадна 2023 оны 3 сарын 27-ноос 4 сарын 25-ны хооронд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад хүүхдийн эрхийн асуудлаар нээлттэй хяналт шалгалтыг хийсэн.

Б.Жаргалмаа - ХЭҮК-ын дарга Х.Хунан даргад баярлалаа. Үнэхээр хүүхдийн асуудал орхигдсон, хамгаалуулах эрх нь зөрчигдсөн, бодлого хууль эрх зүйн орчин хэрэгжихгүй, хангалтгүй байгаа гэдэг ийм дүгнэлтийг ХЭҮК-оос хийж байна.

Дараагийн илтгэгчийг урья. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч Н.Өлзийхутаг мэдээлэл хийнэ.

Н.Өлзийхутаг - Сайн байцгаана уу? Монгол Улсын Их Хурлын гишүүд болон энэхүү хяналтын сонсголд оролцож байгаа төрийн болон Төрийн бус байгууллагын төлөөлөл Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг байна. Та бүхэндээ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн эрхийн талаарх, хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт ямар байгаа вэ гэдэг талаар товчхон мэдээлэл

өгөхөөр бэлдсэн байгаа.

Эхлээд юуны өмнө статистик мэдээллийг та бүхэндээ хүргэе. Нийтдээ манай улсын хүн амын тоо 3,4 саяд хүрсэн, нийт 920 мянган гэр бүл байна. Үүнээс 0-18 насны хүүхэд 37 орчим хувийг эзэлж байгаа. Сүүлийн жилүүдэд ялангуяа хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж байна. Хүүхдийн эрхийн асуудал зөрчигдөж байна гэдэг нэлээдгүй асуудал гарч байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой энэ статистик тоонуудаас харахад гэмт хэргийн улмаас хохирсон 2022 оны тоон мэдээллээр бол 2014 хүүхэд байна. Хүүхэд оролцсон гэмт хэрэг 1258, гэмт хэрэгт холбогдсон 1540 хүүхэд, гэмт хэргийн улмаас амь насаа алдсан 92, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд 205, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 117, хүүхдийн эрхийн Хууль зүйн хороогоор 1491 хүүхэд 2022 онд үйлчилгээ авсан байгаа.

Хүүхэд хамгаалалттай холбоотой 2021, 2022 онд бид эрх зүйн хувьд ямар шинэчлэл хийсэн юм бэ гэвэл, Төсвийн тухай хуулийг дагалдуулж Хүүхэд хамгааллын хуулийн дагуу ерөнхийдөө хүүхэд хамгааллын зардал, норматив зардлыг баталсан. Шинээр хүүхэд хамгааллын үйлчилгээний журмыг батлуулсан байгаа. Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, хамгааллын үйлчилгээний норматив, зардал санхүүжүүлэх аргачлалыг батлуулсан. Үүнээс өмнө ялангуяа бидэнд ийм норматив тогтоох ямар нэгэн үнэ тарифгүй явж ирсэн. Тийм учраас хүүхэд хамгааллын зардал дээр нэлээн задгай байсан байх аа гэж ингэж үзэж байна. Одоо бид 3 түвшиндээ үйлчилгээ үзүүлнэ. Үйлчилгээ маань өөрөө үнэ тарифтай, норматив зардалтай болсон гэдгийг хэлье.

Мөн 2017 онд батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх Төрийн бус байгууллагын магадлан итгэмжлэх журам” шинэчилсэн байгаа. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журмыг 2021 онд 2 сайдын тушаалаар шинэчилсэн. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журмыг шинэчилсэн. Мөн бид 5 хууль түүнийг дагалдаж гарсан 50 орчим дүрэм журам, нийтдээ 8 стандарт энэ бүх хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьд шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэсэн 3 түвшинд авч үзэж үйлчилгээгээ үзүүлж байгаа.

Манай “Хүүхдийн тусламжийн 108” утас 24 цагаар дуудлага мэдээллийг шуурхай хүлээж авч шаардлагатай үйлчилгээг үзүүлж байна. Мөн холбон зуучлах ажлыг бол хийж байна. 2022 онд хүүхдийн тусламжийн 108 утсанд жилийн эцсийн байдлаар 111326 дуудлага ирсэн. Эндээс зорилтот хүүхэд хамгааллын дуудлага 9294, шийдвэр гэсэн кэйсийн тоо 6670 байгаа юм. Бид хүүхдийн тусламжийн 108 үйлчилгээний төвийнхөө программын 3 дахь шатны шинэчлэлийг хийсэн 2020 онд эхлүүлээд 2021 онд дууссан. Тэгээд 108 утасны шинэчлэл хийснээр ямар давуу талтай вэ гэвэл утасны 3 оператораар бид үнэ төлбөргүйгээр мессеж хүлээж авдаг болсон. Мөн үнэгүй чат үйлчилгээг үзүүлж байгаа. Ингээд чат бокс буюу сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх шинэчлэлийг 108 утасныхаа гуравдагч этгээдийн программын шинэчлэлийн үед хийсэн. 2023 оны эхний хагас жилийн дүн мэдээгээр

харахад нийтдээ 74923 дуудлага одоогийн байдлаар ирсэн байна. Энэ жил бид сар болгон Кэйс конференцийг зохион байгуулаад, 108-аас Кэйс үйлчилгээгээ бол орон нутагтаа шилжүүлдэг. Тэгээд энэ ажлыг бид сар бүр эндээ дүгнэлт хийгээд кэйс шийдвэрлэлтдээ маш их анхаарч байгаа.

Б.Жаргалмаа – Н.Өлзийхутаг даргад баярлалаа. Цагдаагийн ерөнхий газар (цаашид “ЦЕГ”-гэх)-ын Хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчил хүчирхийллийн талаар Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга цагдаагийн хошууч Г.Мөнхбаяр таныг урьж байна.

Г.Мөнхбаяр - Та бүгдийн энэ өдрийн амрыг эрэн мэндчилье. ЦЕГ-аас 2022 онд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг болон 2023 оны эхний 6 сарын байдлаар гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг товч танилцуулья.

2023 оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн байгууллагын хэмжээнд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн 960 гэмт хэрэгт 990 хүүхэд хохирсон. Үүнээс 33 хүүхэд нас барж, 364 хүүхэд гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүүхэд 49 буюу 5.2%-аар, гэмтсэн хүүхэд 48 буюу 15.2%-аар тус тус өссөн, нас барсан хүүхэд 3.3 буюу 8.3%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн улмаас нийт 717 гэмт хэрэг үйлдэгдсэнээс 6 хүүхэд холбогдож, 77 хүүхэд хохирсноос 3 хүүхэд нас барж, 44 хүүхэд гэмтсэн үзүүлэлттэй байна.

Хүүхэд хохирсон зөрчлийн талаар танилцуулбал эхний хагас жилийн байдлаар зөрчлийн улмаас насанд хүрээгүй 640 хүүхэд хохирсноос Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчилд 516, хүүхдийн эрх зөрчих зөрчилд 1303, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах зөрчилд 19, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчилд 26 хүүхдүүд тус тус хохирсон байна. Мөн оршин суугаа газраасаа сураггүй алга болсон гэх 599 хүүхдийг цагдаагийн байгууллагаас **АСАП** санд эрэн сурвалжлуулж зарлаж 585 хүүхдийг олж тогтоон ар гэр, асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгсөн байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоон судалгааны хувьд 2018 онд нийт гэмт хэргийн улмаас 1688 хүүхэд хохирсон, 2019 онд 1598 хүүхэд хохирсон бол Ковидын буюу цар тахлын үеүдэд 1181 болон 1365 болтлоо буурсан үзүүлэлттэй байна. 2022 оноос үндсэндээ 2014 гэмт хэрэг бүртгэгдсэн. Ийм статистик тоон үзүүлэлттэй байна.

Мөн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг илрүүлэх, цагдаагийн байгууллагын судалгаа хяналтын санд бүртгэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид тавих хяналтын нэг бүрчилсэн хяналтыг сайжруулах зорилгоор хүүхэд хамгаалал ерөнхий арга хэмжээг зохион байгуулсан. Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн Хүүхдийн нэгдсэн сангийн бүртгэлд бол нийтдээ

1572 хүүхдийг бүртгэсэн. Ингээд эрсдэл арилгах хүртэл хяналтыг хэрэгжүүлснээс орон нутагт 1029 буюу 65.4%, нийслэлд 543 буюу 34.6%-ийг бол эзэлсэн ийм үзүүлэлттэй байна.

Түр хамгаалах болон нэг цэгийн байртай холбоотойгоор улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгааллын 21 түр хамгаалах байр, 14 нэг цэгийн үйлчилгээний төв нийт 35 байр үйлчилгээ явуулж байна. Энэ оны эхний 6 сарын байдлаар 960 иргэнд үйлчилснээс насанд хүрсэн эмэгтэй 148, насанд хүрсэн эрэгтэй хүүхэд 811 байгаа. Нэг цэгийн үйлчилгээтэй холбоотойгоор нийтдээ 1181 иргэн үйлчлүүлснээс насанд хүрсэн эмэгтэй 569, насанд хүрсэн эрэгтэй 42 хүүхэд 579 тус тус бүртгэгдсэн.

Нэг шинэлэг ажил гэх юм бол гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гэмт хэргийн болон хохирогчид нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байраар үзүүлсэн тусламжийг 2018 оны 4 дүгээр сараас эхлэн бид бүхэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (цаашид “ХНХЯ”-гэх)-тайгаа хамтраад E-gbv буюу бүртгэлийн системийг бий болгосон. ХНХЯ дээр И-тусламж /E-tuslam/ гэсэн системтэйгээр хяналт шалгалтыг бол зохион байгуулаад ажиллаж байна.

Хүүхэд болгон өртөж хохирсон шалтгаан нөхцөлүүдийн талаар түрүүн статистик тоо мэдээлэл дээр дурдчихсан байгаа.

Энд саналаа хэлээд явчихъя.

Цагдаагийн байгууллагаас хүүхдийг бэлгийн аливаа хүчирхийллээс өөрийгөө хамгаалах чадвар эзэмшүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын 1-3 дугаар ангийн сурагчдын сургалтын хөтөлбөрт “хүрэхүйн” тухай ойлголт өөрийгөө хамгаалах мэдлэг олгох, 9-12 дугаар ангийн сурагчдад бэлгийн боловсрол олгох чиглэлээр сургалтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах талаар Боловсрол, шинжлэх ухааны яамны ажлын хэсэгтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Мөн бага насны хүүхдийг хүчиндэх, хүн худалдаалах, залилах зэрэг гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдүүдийн талаарх хувийн мэдээллийг агуулсан веб хуудас нээнэ. Иргэд олон нийтэд ил болгох дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, захиргааны хяналтыг тавих ажилд ашиглаж ял шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусахад тухайн веб хуудаснаас мэдээлэл устгадаг байх ажлыг зохион байгуулахаар хууль эрх зүйн орчныг судалж байна. Мөн сүүлийн жилд АНУ-ын сураггүй алга болсон болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах үндэсний төвийн үйл ажиллагаанд ашиглагддаг **Сайпер тип** системийг 2022 оноос цагдаагийн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн. Үүнийг ашигласнаар нийтдээ 2023 оны эхний 6 сарын байдлаар давхардсан тоогоор 7202 мэдээллийг цагдаагийн байгууллагаас илрүүлсэн. Үүнээс цахим орчинд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн садар самууныг сурталчилсан, уруу татсан, хүүхэд оролцсон, садар самуун агууламж бүхий контентыг хадгалсан, түгээсэн, борлуулсан, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нийт 269 мэдээлэлд шалгалтын ажиллагаа явуулж байна. Танилцуулж дууслаа.

Б.Жаргалмаа – Баярлалаа. Сонсголын сэдэвтэй холбогдуулан холбогдох байгууллагууд мэдээлэл, дүгнэлтээ танилцуулж дууслаа. Мэдээлэл дүгнэлт болон хүүхдийн бүх орчинд хамгаалагдах эрхийн талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд оролцогчдоос асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү?

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.5-д заасны дагуу гишүүн тус бүр 20 минут хүртэлх хугацаанд хэдэн ч асуулт асууж хариулт авч болно. Ер нь энэ хяналтын сонсгол маань хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус болон төрийн байгууллагууд, албан тушаалтнууд хуулийн хэрэгжилтийг ямар хэмжээнд хийж авч явж байна, хүүхдийн эрх хэрхэн хамгаалагдаж байна вэ гэдэг тайлангаа сонсдог. Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод тайланг сонсоод, шийдвэр гаргах, шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хуралд танилцуулах ийм дэгтэй. Тэгэхлээр Та бүхэн гишүүдийнхээ асуултад хариултаа өгөөд, ямар арга хэмжээ авах шаардлагатай байгаа гэдгээ г хариулахдаа бас хэлж болно.

Ц.Идэрбат гишүүнээс эхэлж байна. Бүгдээрээ асуух юм уу?

Ц.Идэрбат - Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ бол нийгмийн нэлээн чухал асуудал яригдаж байна гэж ойлгож байгаа юм. Мэдээлэл хийсэн 3 байгууллагын илтгэлээс ХЭҮК, манай бүтэц олигтой ажиллахгүй байна. Бүтэц өөрөө буруу байна. Гэр бүл хүүхэд, залуучуудын газар бол гарсан кэйс дээр ажиллаж, кэйсийг арилгахын төлөө л ажиллаж байна. Цагдаа бол мэдээж тоон үзүүлэлт, харамсалтай нь тоон үзүүлэлтүүд өссөн ийм л дүр зурагтай байна. Тэгээд би эндээс амьдралд ойрхон ийм дүгнэлтүүд гарсан юм болов уу гэж харж байна. Ялангуяа орон нутагт ажиллаж байсан хүний хувьд, энэ хүүхэд хамгааллын анхан шатын нэгж дээр ажиллаж байсан хүний хувьд ойлгомжгүй зүйл маш их байдаг.

Нэгдүгээрт хүүхэд хамгааллын чиглэлээр олон л асуудлууд байгаа. Миний хувьд онцолж ярих гэж байгаа зүйл бол энэ хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулах хамгийн анхан шатын нэгж бол хамтарсан багийн үйл ажиллагаа байдаг. Хамтарсан багийн үйл ажиллагаан дээр эмч, цагдаа, багийн ажилтан, нийгмийн ажилтан нар орно. Тэгээд явж явж нөгөө багийн нийгмийн ажилтан л үлддэг. Цагдаа өөрөө ажилтай, өрхийн эмч өөрөө ажилтай. Харамсалтай нь энд нь нэг ч төсөв байдаггүй. Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв сүүлийн 3 жил тогтмол 8 тэрбум явж ирсэн юм байна. Бид жоохон үр дүн гаргая гэвэл энэ анхан шатны ялангуяа баг, хороо дээр байгаа хамтарсан багийнхаа үйл ажиллагааг явуулах тал дээр хаана хаанаа анхаармаар байдаг юм. Энэ дээр ер нь өнгөрсөн жилүүдэд яг юу хийгдсэн бол?.

Жишээ нь тэр ажлаа амжихгүй байгаа цагдааг тийш нь яаж явуулах юм, тэр өрхийн эмчийг яаж явуулах юм. Тэд нар чинь үндсэн ажил руугаа анхаараад хамтарсан багийн үйл ажиллагаа руу нэг их анхаарч чаддаггүй шүү дээ. Ер нь яг

амьдрал дээр урамшуулал байхгүй.

Үүнийг жоохон өөрчилчихвөл үр дүн гарна. Хамтарсан багийн зардал гэдэгт хамтарсан баг ажиллаад үйл ажиллагаагаа явуулахаар нэг их тийм сүртэй юм байдаггүй шүү дээ. Би аймгийн төвийн нэг баг дээр 500-600,000-ыг тавьж үзэж байсан. Үр дүн гардаг л юм байна лээ. Тэгэхээр энэ талаар ер нь Гэр бүл хүүхэд залуучуудын газар төсөв санхүүтэй холбоотойгоор орон нутагтай хамтрах зүйл дээр ямар санаачилга гаргаж ажиллав аа?

Хоёрдугаарт нэг кэйс гарлаа. Тэгээд бүгдээрээ сүйд болоод л очно. Эхний 3 хоног сүртэй байж байгаад 4 дэх хоногоос байхгүй болдог. Хүүхдийг хаана аваачиж байрлуулах вэ? Нэг байранд аваачна. 3 хоног болгоно, 4 дэх өдрөөс зардал нь хаана байх вэ? Тодорхойгүй. Нөгөө муу багийн нийгмийн ажилтан өөрөөсөө өгч эхэлдэг. Тэгээд эцэг эх нь хоёулаа архины хамааралтай байдаг юм уу, үр хүүхдээ тоохгүй бол цаашдаа тэр хүүхдийг яах вэ? Долоо хоногийн дараа эргээд гэрт нь хүргэж өгдөг. Бахь байдгаараа л угтдаг тэр хүүхдийг. Тэгэхээр цаашдаа ер нь бид яг яах ёстой юм бэ?

Гуравдугаарт сургуулийн нийгмийн ажилтны холбооны удирдлагууд байх шиг байна. 3000-2000 хүүхэдтэй сургуульд нэг нийгмийн ажилтан байдаг. Гэвч нийгмийн ажилтан яг үндсэн үүргээ гүйцэтгэж чаддаггүй, зүгээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг хүн болж хувирдаг. Яг тэр 3000 хүүхдээс эмзэг бүлгийн гэдэг юм уу, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдийн судалгаа аваад ингэж ажилладаг уу? Боловсролын салбар энэ дээр бас нэлээн анхаараад ялангуяа гадаадын туршлага шиг хичээлдээ ирэхгүй байгаа хүүхэд, нөгөө үл хайхрах байдалд өртөөд байгаа хүүхдийн судалгааг анги удирдсан багш, дунд ангид хичээл орж байгаа багшийн мэдээлэл цугладаг уу? Энэ дээр нийгмийн ажилтны холбооныхон ер нь ямархуу байр суурьтай байдаг юм бэ?

Магадгүй энэ 2 асуудал дээр бид нар зөв ажиллаж чадах юм бол энэ хүүхдийн эрхийн ялангуяа энэ үл хайхрах байдаг юм уу ийм зүйлүүд бол нэлээн хумигдана гэж ингэж боддог. Боловсролын салбарын хамрагдалт бид дэлхийд дээгүүр ордог.

Мөн би хэн хариулахыг нь мэдэхгүй байна ЗГХЭГ-аас төрийн байгууллагуудын процессын дахин инженерчлэл гэдэг зүйлийг ярьж эхэлж байгаа юм. Яг ямар байгууллага нь юу хийх юм, ямар албан тушаалтан, ямар үүрэгтэй юм бэ гэдгийг оруулах гээд байгаа. Тэгэхээр бид хүүхэд хамгааллын асуудлыг нэгэнт л энд ярьж байгаа бол тэр 8 тэрбум төгрөгөөсөө байдаг юм уу, дахиж нэмж төсөв байдаг юм уу, ялангуяа 1600 баг л гэж яриад байгаа болохоос 21 аймгийн төвийн хэдэн багууд, дээр нь нийслэлийн 100 гаран хорооны л асуудал байгаа шүү дээ. Энэ дээр хамгааллынхаа асуудлыг яриад, энэ инженерчлэл гэдэг зүйл дээр хүүхэд гарсан кэйсээс нь авхуулаад яаж урьдчилан сэргийлэх, зэрэг асуудлыг хийх ямар төлөвлөгөө байгаа вэ?

Өнөөдөр хэдүүлээ ингээд нүүр тулж ярьсан дээрээ нэлээн тодорхой шийдвэртэй гараасай билээ гэж би бодож байгаа. Тэгэхгүй ингээд хэдэн биеийнхээ

юмыг сонсоод, “тийм шүү” гээд толгой дохиод гарвал өнөөдөр ямар ч үр дүн байхгүй.

Дээрээс нь надад сүүлийн үед ирж байгаа мэдээллүүдээр Хүүхдийн хүчирхийлэл их байна, Хүүхэд янз бүрийн хүчирхийлэлд их өртөж байна, үл хайхрах хүчирхийлэлд их өртөж байна гэж байна. Энэ орон зайн дээр янз бүрийн хүүхдийн нэртэй асрамжийн газрууд маш их байгуулагдсан гэж байгаа. Санхүүжилтийн хувьд бол бас яг хаанаас гэдэг нь тодорхой биш байдаг. Төрийн байгууллагууд тэнд шалгалт хийхдээ байр байшин, хоол унд нь болж байна уу л гэхээс биш яг цаад үндсэн үйл ажиллагаа, тэр сурч мэдэх эрхийг хангаж байгаа эсэх дээр ер нь ямархуу шалгалтууд явдаг вэ?

Бид зөвхөн хүүхдийг хоолтой дулаан байртай байлгах асуудал ярихаас гадна тэрний дараагийн том асуудлыг бид бодож байх ёстой. Төрийн байгууллагууд ч гэсэн үүнд анхаарлаа хандуулж байх ёстой. Миний ойлгосноор бол 100-гаад асрамжийн газрууд байдаг гэж дуулдаад байгаа юм. Тэгэхээр би үндсэндээ энэ асрамжийн газартай нийлээд 4 асуултад товчхон хариулт авъя гэж бодож байна. За баярлалаа.

Б.Жаргалмаа - Энэ 13 минут дотроо багтаад л хариулт өгөөд явагдах ёстой юм байна. Өөрөөр хэлэх юм бол 20 минутдаа асуулт хариулт нь хамтдаа явах юм байна. Хэн хариулах вэ? ХНХЯ-аас уу? Н.Өлзийхутаг дарга уу?

Н.Өлзийхутаг - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд хамтарсан багийн бүтэц чиг үүргийг тусгасан. Энэ хуулийн дагуу харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын зардлыг нь Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн орон нутгийн иргэдийн хурал хариуцах ёстой гэж заасан. Гэтэл яг үнэндээ бол хамтарсан баг маань өнөөдөр зардал бараг байхгүй шахам хэмжээнд байгаа. Бид хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал болон хүүхэд хамгааллын зардлаасаа 2022 онд 430 гаруй сая төгрөгийг кэйс шийдвэрлэлтэд зориулж хамтарсан багт олгосон байгаа. Энэ зардал жил бүр ер нь нэмэгдээд явж байгаа юм. Тухайлбал 2020 онд 250 сая, 2021 онд 352 сая, 2022 онд 481 сая төгрөг гээд нэмэгдээд явж байгаа. Хамтарсан багийн үйлчилгээний мэдээллийн санг бол цахимжуулсан. Нийгмийн ажилтны мэдээллийн сан “namsgov.mn” программыг хөгжүүлсэн байгаа. Мэдээллийн системд хамтарсан багийн нийгмийн ажилтан маань бол бүртгэл мэдээллийг оруулна. Энэ дагуугаа норматив зардал олгогдохоор ингэж тусгагдсан. Нийтдээ 735 хамтарсан баг байгаа юм. Өнгөрсөн жил бид НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр манай яамнаас нийгмийн ажилтанд таблет олгосон. Тэгэхээр энэ таблетаараа дамжуулаад мэдээллийн системдээ мэдээллээ оруулаад байх юм бол бас тодорхой үнэ тарифтай болсон гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Хамтарсан багийг чадавхжуулах ажлыг манай ХНХЯ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, манай агентлаг хамтраад тасралтгүй хийж байгаа. Бид 2022 онд Нийслэл хотын 204 хороонд яг нэг бүрчлэн цагдаагийн байгууллагатайгаа хамтарч, очиж ажилласан.

Кэйс бүртэй нь танилцсан, хороо бүрээр орсон. Анхан шатан дээрээ хүүхэд гэр бүлтэй ажилладаг нийгмийн ажилтан бол байхгүй байгаа нь өөрөө асуудал үүсэх хамгийн том нөхцөл болоод байгаа. Яг үнэнийг хэлэхэд аймаг дээр ажиллаж байна, дүүрэгт ажиллаж байна. Гэтэл анхан шатан дээр үйлчилгээ үзүүлдэг гэр бүл хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан байхгүй байгаа. Хүүхэд хамгааллын хуулийн төсөлдөө бид энэ бүтцийг тусгасан байгаа. Хэрвээ одоо үнэхээр 735 хороо маань хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтантай болох юм бол анхан шатан дээрээ бид үйлчилгээнийхээ хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг нь сайжруулах тал дээр илүү ахиц гарна гэж харж байна.

Б.Жаргалмаа - Дараа нь хэн хариулах вэ? Ц.Идэрбат гишүүн тодруулж асуух уу?

Одоо бидэнд юу хэрэгтэй байгаа вэ? Үнэхээр хүүхэд хамгааллын мөнгө маань бидэнд хүрч байгаа юм уу? Сая Н.Өлзийхутаг даргын хэлж байгаагаар анхан шат дээр нийгмийн ажилтан хэрэгтэй байна гээд яг гол гол хариултуудаа өгөөд явбал уг нь зүгээр байна. Боловсролын яамнаас сургуулийн нийгмийн ажилтан ямар хэмжээнд ажиллаж байгаа юм? Тэгээд 100 гаруй асрамжийн байгууллага байна гэдэг зүйл ярьсан зүйл дээр тодруулга мэдээлэл өгчих үү.

Товч тодорхой яг асуултад л хариулья.

Х.Хунан – Ц.Идэрбат гишүүний асуултад хариулт өгье гэж бодож байна. Хариулт ч юу байх вэ тайлбар хийе гэж бодож байна. Үнэхээр та сайн харсан байна. Хүүхэд хамгааллын асуудлаа бид нар ер нь дандаа давхар, хавсаргаж яваад байгаа юм байна. Өөр асуудалтай бид нар дандаа хавсарч хийж байгаа учраас энэ орхигдож байна. Яг хүүхдэдээ чиглэсэн бодлого байхгүй.

Ялангуяа орон нутагт төсөв байхгүй, боловсон хүчин байхгүй, ХЭҮК-оос явуулсан хяналт шалгалтын 40 хамтарсан багт ерөөсөө 62% нь мэргэшсэн нийгмийн ажилтан байхгүй гэсэн. Өөрөөр хэлбэл тэр асуудлыг ойлгодог, мэддэг, ач холбогдлыг нь бүрэн мэдсэн хүн байхгүй. Тэгэхээр анхан шатны нэгж дээр нь яг хүүхэд хамгааллын асуудал хариуцсан нийгмийн ажилтан байх хэрэгтэй. Хүүхэд хамгааллын ажлыг зохион байгуулдаг, хооронд нь уялдаа холбоог нь хангадаг. Өнөөдрийн хамтарсан баг бол уг нь их зөв концепц байхгүй юу. Мэргэжлийн байгууллагын төлөөлөл хамтраад энэ хүүхдийн асуудал дээр бид нар яах вэ? ямар арга хэмжээ авах вэ? гэдэг төлөвлөгөө гаргаад явах ёстой. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо чинь яг ялгаа байхгүй, мөн адил маш олон төлөөлөл тал талаас нь хараад энэ хүүхэд дээр, гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд дээр ингэж ажиллая гээд хамтраад төлөвлөгөө гаргаад явах ёстой байдаг. Гэтэл үүнийг хариуцсан хүн байхгүй дандаа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст нэг хүн нийгмийн ажилтан үгүй бол нийгмийн ажилтан байхгүй байлаа гэхэд өөр мэргэжилтэн хариуцаад яваад байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар ч байсан боловсон хүчнийг нэн тэргүүнд байлгах ёстой юм байна. Ялангуяа хүүхдийн асуудал хариуцсан анхан шатын нэгж дээр нэг хүн зайлшгүй байх ёстой. Нийгмийн ажилтан нь байна уу эсгүй бол хүүхдийн

эрхийн байцаагч байна уу? Үүнийг бид нэн тэргүүн шийдэх ёстой, төсвийг шийдэх ёстой. Хамтарсан багт төсвийг нь зайлшгүй шийдэж өгч байж энэ асуудал цааш нь явна. Орон нутагт ялангуяа сум бол ямар ч төсөв байхгүй. Зарим нэг хамтарсан багийн төсөв нь жилийн 2 сая төгрөг гэж байгаа. Үүгээр юу ч хийж чадахгүй. Тэгээд бид нар энэ нөхцөл байдлаа бас бодитой дүгнэмээр байгаа юм. Яагаад гэвэл түрүүн таны хэлдгээр суманд ерөөсөө үндсэндээ бол яг цагдаагийн алба хаагч 2 л хүн байдаг. Тэгэхээр бусад асуудлаа яах юм гэдэг асуудал.

Өнөөдөр бид нэгдүгээрт, хүүхдийн асуудлыг дээд эрх ашиг гэж байгаа бол энэ хүүхдийн эрхийн асуудал хариуцсан нийгмийн ажилтныг ерөөсөө бодлогоор гаргаж ирж бүх анхан шатын нэгж дээр нэг хүнийг заавал байлгах ёстой. Ингэж байж хамтарсан багийн хоорондын уялдаа холбоог нь хангана. Салбар хороо салбар хоорондын ажлын уялдаа холбоог хангаж ажиллана. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо үр дүнгээ өгнө.

Б.Жаргалмаа - За уучлаарай нөгөө 2 асуултад бас хариулт авахгүй бол болохгүй. Боловсролын яамнаас тайлбар өгөх үү? За та өөрийгөө танилцуулаарай.

Б.Мөнхжаргал - Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн Мөнхжаргал.

1997 оноос хойш боловсролын салбар дэлхийн жишгээр сургуулийн нийгмийн ажилтан гэдэг мэргэжлийг бий болгоод өнөөдөр 26 жил хөгжиж байна. Ц.Идэрбат гишүүний асууснаар үнэхээрийн 3000 хүүхдэд нэг нийгмийн ажилтан ажилладаг. Сүүлийн 2 жил 2000 хүүхдэд нэг нийгмийн ажилтан ажиллаж байгаа. 1500 хүүхдэд нэг нийгмийн ажилтан ажиллана гэдэг жишиг байдаг гэхдээ энэ биелэгддэггүй.

Өнөөдөр олон улсын жишиг нь 600 хүүхдэд нэг нийгмийн ажилтан ажиллаж байгаа. Тэгэхээр Монголд ядаж 1000 хүүхдэд нэг нийгмийн ажилтан оногдох шаардлагатай байгаа. Нөгөө талаасаа сургуулийн нийгмийн ажилтан хүүхэдтэй ажилладаг, хүүхэд хамгааллын чиглэл дээр ажилладаг мэргэжилтэн. Тэгэхлээр хамгааллынхаа чиглэл дээр ажилладаг ажил дээрээ өөрийнхөө карманаас мөнгөө гаргаад ажилладаг ийм хүмүүс байдаг. Дээрээс нь хамтарсан багт, яг суман дээр хүүхдийн нийгмийн бодлогын түшмэл ганцаараа ажиллаж байна. Энэ түшмэлийн ажлыг хэн хийдэг вэ гэхлээр сургуулийн нийгмийн ажилтнууд хийдэг. Ямар ч нэмэгдэл хөлс байхгүйгээр эд нар ажилладаг.

Тийм учраас бид өнөөдөр энэ хуулиараа суманд хүүхдийн асуудлыг хариуцсан хүнтэй байгаач ээ гээд байгаа нь аргагүй. Сургуулийн нийгмийн ажилтан сумын нийгмийн бодлогын түшмэл биш, нийгмийн ажилтантай хамтраад ажиллах юм бол хүүхдийн асуудал өөрчлөгдөнө.

Бид өнөөдөр боловсрол дээр анги удирдсан багшаар дамжуулаад эрсдэлийн үнэлгээг хийлгүүлж байгаа. Эрсдэлийнхээ хүүхдүүдийг тооцож байгаа. Үүнийг илүү сайжруулж цахимжуулах хэрэгтэй гэж үзэж байгаа. Харин

Боловсролын яаманд талархаж байна. Сургуулийн нийгмийн ажилтны ажилтнуудын цалинг маань нэмэгдүүлж сургалтын менежертэй адилхан болгосон. Бид анх эхлэхдээ яг ингэж эхэлж байсан. Тэгээд сургуулийн нийгмийн ажилтны ажилд өөрчлөлт гарна. Одоо батлагдах гэж байгаа хууль дээр хүүхэд хамгааллын зардалтай болох гэж байгаа юм шиг байна лээ. Боловсролд энэ их зөв шийдэл. Тэгж байж сая сургуулийн нийгмийн ажилтан, сургууль, боловсрол мөнгөтэй байж байж тэр эрсдэлт бүлгийнхээ хүүхдийг хамгаалах ажилд ахиц гаргана гэж үзэж байна.

Б.Жаргалмаа - Асрамжийн газар дээр ямар хариулт өгөх вэ? Н.Өлзийхутаг дарга 2 дугаар микрофон.

Н.Өлзийхутаг - Өнөөдөр улсын хэмжээнд хүүхдийн асрамж халамжийн 31 төв үйл ажиллагаа явуулж байгаа. Үүнээс улсын төсвөөс санхүүждэг 3 төв байна. Бусад нь Олон улсын байгууллага, ТББ, хувь иргэний өөрсдөө байгуулсан ийм асрамж халамжийн төвүүд байгаа. Асрамж халамжийн төвд амьдарч байгаа хүүхдүүдийн тоо өнгөрсөн жилээс арай буурсан. 1100 орчим хүүхэд байсан, 2023 оны хувьд бол 970 орчим хүүхэд асрамж халамжийн төвд өнөөдөр хүмүүжиж байгаа. Ялангуяа асрамж халамжийн төвүүдийн нэг асуудал нь бол насанд хүрээд бие даан амьдрахад энэ хүүхдүүдийн асуудал маш хүндрэлтэй байгаа. Төрөл садан байхгүй, эцэг эх байхгүй, 18 нас хүрээд асрамж халамжийн төвөөс гарахад тэд хаашаа очих вэ, яаж амьдрах вэ? Бас ноцтой кэйсүүд ч гарч байгаа. Өнгөрсөн жил төвөөс гарсан хүүхэд амиа хорлолтод хүрсэн байдал бол ажиглагдсан. Тэгэхээр энэ мэтчилэн асуудал дээр ялангуяа бид нар бодлогын түвшиндээ маш томоор анхаарах шаардлага байгаа гэж харж байна.

Б.Жаргалмаа - Ц.Идэрбат гишүүн

Ц.Идэрбат - Ерөнхийдөө ХЭҮК-ын дүгнэлтээр бидний хүүхэд хамгааллын чиглэлээр яваад байгаа ажил маань болохгүй байгаа гэж гараад байгаа учраас бид үүнийг бараг нөгөө араг ясаа босгохоосоо авхуулаад л их зөв хиймээр л надад санагдаад байдаг юм.

Тийм учраас байгууллага, байгууллагын олон хүмүүс цугларсан байгаа дээр бид нарын өнөөдөр явж ирж байгаа энэ тогтолцоо, мөнгө хоёроо зэрэгцүүлж тавьж байгаад яг яаж явах юм бэ гэдгээ л нэг зөв гаргачихвал цаашаа явчихна. Бидэнд бас их давуу талууд байгаа шүү дээ.

1-т Манай хүн ам цөөхүүлээ,

2-т Боловсролын салбарт 97%-тай хамрагдчихсан. Тэнд чинь бас цаагуураа нэг бүртгэл явагдаад байна шүү дээ. Тэгэхээр ЦЕГ, Боловсрол, шинжлэх ухааны яам, ХНХЯ гэсэн энэ 3 байгууллага бүтэц зохион байгуулалтаа зөв хийгээд яваасай билээ. Би та бүхний тайлбараас бол яах вэ нийгмийн ажилтны цалин нэмэгдсэн нь сайн байна. Стандарт нь бас хараахан болоогүй байгаа. Цалин нэмэгдлээ гээд тэр хүний ачаалал буурахгүй шүү дээ. Байдгаараа л байна. Тийм биз. Тэр нийгмийн ажилтныг анхан шат дээр ажиллууллаа гээд бас л мөнгөгүй бол нэг орон тоо л нэмэгдэнэ.

Ер нь зүгээр энд сонирхуулаад хэлчихэд баг хороон дээрээс төрийн бүх шатын судалгаа гардаг шүү. Тэр ганц хүүхдийн асуудал яриад суугаад байж чаддаггүй байхгүй юу. Жилийн эцэст 24-25 төрлийн судалгаа гаргадаг. Тэнд асар их ачаалал байдаг. Тийм учраас та бүхнийг хэлээд байгаа нь энэ. ЗГХЭГ-аас төрийн албаны инженерчлэл гэж хийгдэж байгаа. Яг энэ цаг үед хүүхэд хамгааллынхаа асуудлын инженерчлэл, бүтцийг нь их зөв болгох шаардлагатай байгаа юм. Бүх юм тодорхой байгаад кэйс гарлаа, хүүхдийг 3 хонолоо ингэнэ, 4 хонолоо ингэнэ, байр нь бэлэн байна, хоол нь тэр байна. 10 дахь хоногоос ийм юм руугаа шилжинэ гээд л. Ингэхгүй бол их л сүртэй 4 хоног болдог юм шүү. Тэгээд 5 дахь хоногоос эргээд гэрт нь аваачиж өгдөг ийм л юм байгаа юм.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар бол хамрах хүрээ нэлээн өргөн болоод хүүхдийн хөгжил гэхээсээ илүүтэй бараг хүүхдийн хүчирхийлэл рүүгээ нэлээн анхаардаг ийм л байгууллага болж хувираад байгаа юм байна лээ. Ер нь тэнд ажиллаж байгаа хүмүүс ч гэсэн зарим зүйл нь тодорхой биш учраас бүүр толгойны өвчин болчихсон одоо яах вэ, энэ хүүхдийг ингээд орхичихож болохгүй цаашаа явъя гэхээр өөрийнх нь эрх мэдэл хүрэхгүй, төсөв мөнгө байхгүй. За тэгээд нийгэм чимээгүй боллоо гэрт нь хүргээд өгье, ийм л байдалтай байгаа шүү. Тэгэхээр өнөөдрийн цалин нэмэх, орон тоо нэмэх бол зүгээр наад захын л ажлууд шүү дээ. Бүүр ажлынхаа гүн рүү ор л доо, бүтцээ зөв хий л гэж хэлье. Баярлалаа.

Б.Жаргалмаа - Ц.Идэрбат гишүүндээ баярлалаа. П.Анужин гишүүн асуултаа асууя.

П.Анужин - Би асуулт асууя гэхээсээ зүгээр санал бодлоо Та бүхэнтэйгээ хуваалцъя гэж бодож байна. Өнөөдрийн энэ сонсголд оролцож байгаа бүх хүмүүстээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Ер нь аливаа улс орон хувьчилж болдоггүй маш болгоомжтой хүрэх ёстой ийм салбарууд бол байдаг юм байна. Тэгээд 30 жилийн өмнө бид боловсролынхоо салбарт маш их хамаагүй гар хүрч хувьчлалд оруулж явсныхаа горьг одоо яг 30 жилийн дараа ингээд үзэцгээж байна. Энэ дээр илүүтэй юу харагдаж байна вэ гэхээр өнөөдөр Монгол хүний ухамсар гэж ер нь яг ямар юм болчихов гэж. Мэдээж бид нар хүүхэд хамгаалал, хүүхдийн хүчирхийллийн асуудлыг ярихад бол хүүхэд хамгааллын баг, тэдэнд тусгах төсвийн талаар ярина. Гэхдээ үүний яг нөгөө талд нь Монгол хүний ухамсрын асуудал байгаад байна.

Намайг жоохон байхад ноцтой хэргүүд, ялангуяа хүүхэдтэй холбоотой хэргүүд бол өдрийн од шиг гардаг байсан. Гэтэл өнөөдөр бүүр чихэнд бараг сонсоход хэцүү зүйлүүд өдөр бүхэн гарч байна. Энэ яагаад вэ? Ээжтэй нь ханилчихаад хүүхдийг нь хүчинддэг, төрсөн үрээ хүчиндэж байна. Буян номын газар буян ном заана гэххээд хүүхдүүдийг хоморголж аваачаад буруу гаж юманд сургаж байна. Нөгөө талд нь юу вэ гэхээр өнөөдөр байгаа бидний ухамсар, нийгмийн сэтгэл зүйн толь ингээд харагдаад байгаа юм.

Хүүхэд хамгаалал гэдэг бол яах вэ араас нь хөөж байгаа асуудал. Нэг

асуудал гарлаа, түүний хойноос хэвлэл шуугдаг, хүмүүс үзэн яддаг. Ингээд нэг юм болоод л дуусаа. Тэгэхээр ерөөсөө эрүүл мэндийн салбараа аваад үзсэн ч, боловсролын салбараа аваад үзсэн ч нийгмийн бүх асуудлыг аваад үзэхэд бид нар араас нь хөөхөөс л хэтрэхгүй байна.

Тэгэхээр яах вэ? Нийгмийн бодлогын байнгын хороог ахалж байгаа хүний хувьд хэлэхэд эрүүл мэндийн салбар удахгүй өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлдэг, энэ чиглэл рүүгээ мөнгө төсөв тусгах гээд хууль өргөн баригдчихсан байна. Энэ бол том алхам болно. Яг үүнтэй адилхан хүүхэд хамгааллын чиглэлд, ялангуяа хэрэг гарахаас өмнө бид нар ийм зүйлийг нийгмээрээ жигшдэг, хүний энэ дундаж ухамсар өөрөө маш их дээшлэх хэрэгтэй байна.

Хүн бүр дор бүрнээ сэрсэн тэр өөрчлөлт маань 30 жилийн дараа гарах уу, үгүй юу? Аливаа зүйлийг нураах бол их амархан байдаг юм байна. Сайн зүйлээ нураасны дараа босгоход магадгүй 100 жил хэрэгтэй байх. Бид “нэг нь нийтийнхээ төлөө санаа зовдог” энэ ухамсрыг бий болгох гэж 70 жил болсон. Гэвч бид нар энийгээ устгаад хаясан. Одоо бид 30 жилийн дараа Монгол хүний ухамсар сэрэхэд хэчнээн жил хэрэгтэй вэ? Хэн ч таашгүй. Энийг баримжаалж өөрчилж болох юм шиг надад бодогдоод байгаа юм.

Би өөрөө 4 хүүхэдтэй ээж хүн. Хүн бүр дор бүрнээ л эхэлмээр байгаа юм. Хэн нэгний хүүхдийг гэртээ муулмааргүй байна, хэн нэгний үр хүүхдийг доромжилж элдвийн коммент бичмээргүй байна. Хэн нэгний гэр бүлийн талаар аав нь ээж нь гэртээ яримааргүй байна. Эндээс өөрчлөлтийг эхэлдэг. Ер нь нийгмийн том ухамсрын хувьсал зүй бол гэр бүл, эх хүн, сургуулийн орчноос эхэлнэ.

Дээр үед хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын баг гэж байгаагүй шүү дээ. Багш нар л ерөөсөө ангийнхаа хүүхдүүдийн ар гэрийг бүгдийг нь нэг бүрчлэн мэддэг байсан. Тэр багш өөрөө одоогийн энэ төсөв байхгүй байна гэдэг ажлыг хийчихдэг байсан. Хамар хашааныхан хажуу талынхаа айлыг мэддэг байсан. Гэтэл саяхан телевизээр гарч байна лээ. Энэ хажуу талын айл хүүхдээ зодсоор байгаад чирээд гаргадаг, оройдоо зодоод байдаг байсан. Үгүй ээ орохгүй байна шүү дээ. Хажуу талын хүн орохоос айж байна. Өөрсдийгөө эрсдэлээс хамгаалж байна. Энэ өнөөдөр бид нарын байгаа нийгмийн сэтгэл зүй.

Тэгэхээр хүүхэд хамгааллын асуудлыг Улсын Их Хуралд шат дараатайгаар нэмэгдүүлж, энэ хамтарсан багийн санхүүжүүлэлт чадавхын асуудлыг дээшлүүлэх нь маш чухал асуудал хэдий ч бид нар нийгмээрээ энэ зүйлийг жигшдэг, ийм зүйлийг хийхгүй байдаг ухамсар луу явах хэрэгтэй байна гэж бодож байна. Энэ бол 1-2 жил магадгүй, бид алдсан 30 жилдээ засах зүйл биш байх. Бид нар алдсанаа нөхөх гэж магадгүй 2 дахин, 3 дахин их жилийг зарцуулах байх. Гэхдээ хүн бүр дор бүрнээ өөрчлөгдөөсэй. Өнөөдөр ямар нэг Хуралд ирээд нэг сайхан юм ярьдаг. Бүгдээрээ урьд урьдаасаа харж байгаад л цаас, статистик тоо ярьдаг. Энэ чинь эргээд хэнд хэрэгтэй юм бэ? Хэнд хэрэг болоод байгаа юм бэ? Хэнийг өөрчилж байгаа юм бэ?

Бид өнөөдөр энд 40-үүлээ нийлээд суусан бол 40 хүн дор бүрнээ яг өнөөдрөөс, энэ цагаас эхлээд гэртээ үр хүүхэдтэйгээ яаж харьцах вэ, надаар дамжиж үр хүүхэд нийгэмд гараад яаж байна гэдэг энэ асуудал дээр л бодит өөрчлөлт хийхийн төлөө, Монгол Улсын ухамсартай иргэн нэг бүр л хичээж бодох ийм цаг болсон юм уу даа гэсэн бодол маш их төрж байгаа.

Бид нар ноднин жил байх аа Т.Жаргалмаа гишүүн ээ? Хүүхдийн хүчирхийлэл, хамтарсан багийн төсвийг нэмэгдүүлэх асуудлаар бас нэлээн томоохон хэмжээний уулзалтыг Төрийн ордонд Хууль зүйн, дотоод хэргийн яам ахлаад хийж байсан. Тэр үеийг бодвол эрх зүйн хүрээнд нэлээд хэд хэдэн шинэчлэлийг хийхээр улсын төсөвт хүүхэд хамгаалалд зарцуулж байгаа 8 тэрбум төгрөгийнхөө мөшгөлтийг нэлээн ойр ойрхон хугацаанд Төрийн ордонд уулзаж, яаж зарцуулав, зарцуулалт нь ямар байна гэдэг дээр ярьж байна. Тэгэхдээ энэ бол бид нарын гарц биш шүү.

Ер нь энэ аймшигтай зүйлийг үйлдэж байгаа хүний ухамсар ямар байгаа юм, өнөөдөр монголчуудын сэтгэл зүй ямар байгааг судлах цаг болсон байна. Ялангуяа энэ Ковидын дараа хүмүүсийн сэтгэл зүйд асар том хэмжээний өөрчлөлтүүд орсон байна. Нийгмийн сэтгэл зүй тэр чигээрээ сууриараа өөрчлөгдсөн байна. Автобусанд явж байхад настай хүн хажууд зогсож байвал бидний үеийнхэн бол ерөөсөө яс хавтайгаад, хажууд нь сууж чадахгүй. Гэтэл би чихээрээ сонссон. Би хөдөлмөр эрхлээд явж байхад чинь ажил хийдэггүй, та юугаа хийгээд ажлын цагаар автобусанд тэнээд явж байгаа юм гэж хэлж байна. Энэ бол хүйтэрч байна. Хүмүүсийн ухамсар тэс өөр болж байна. Тэгэхээр өнөөдөр нийгмийн хүмүүсийн сэтгэл зүй бид нар үүнийгээ яаж орчин үед нь тохирсон ухамсар зүйг төлөвшүүлэх вэ гэдэг маш том сорилт Монгол Улсын хувьд тулгарч байна гэж би үзэж байгаа.

Өнөөдөр яг энэ цаг үед Монгол Улсын Их Хурлаар Боловсролын багц хууль хэлэлцэж байгаа. Тэгэхдээ бид хэлбэрийг хэлбэрчлэхийн төлөө хуульчлах нэг хэрэг. Харин энэ хэлбэр, агуулга дунд зайлшгүй явах ёстой. Хүнээ төгөлдөршүүлэх, хүнээ хөгжүүлэх, хүний хөгжил гэж яриад байгаа ч яг яаж гэдгээ бид нар мэдэхгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг л салбар бүр, хүн бүр, иргэн бүр бодох л цаг үе байна гэж би бодож байна. Тэгээд юугаа асуух юм?

Тийм учраас би саналаа хэлж байна. Хүн бүр өөрчлөлтийг дор бүрнээсээ эхлэх цаг болсон шүү гэдгийг би энэ сонсгол дээр хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Б.Жаргалмаа - П.Анужин гишүүндээ баярлалаа. Хүүхэд хамгааллын асуудал дээр нийгмийн энэ чиг урсгалыг тодорхой хэмжээнд иргэн бүр өөрсдөө өөрчлөх тэр ёс суртахуун ухамсартай байх ёстой. Энэ дээр бид ажиллах ёстой шүү гэдэг саналыг П.Анужин гишүүн маань хэллээ. М.Оюунчимэг гишүүн одоо асуултаа асууя.

М.Оюунчимэг - Та нартаа энэ өдрийн мэнд хүргэе. Хүүхэд хамгааллын чиглэлээр, яг энэ асуудалтай холбоотой бүхий л байгууллагын төлөөллүүд байна. Тэгээд энэ анх удаа хийж байгаа уулзалт биш. Миний мэдэхээр 2017 оноос хойш

жил болгон л ингээд хийж байна. Тэгээд танин мэдэхүйн шинжтэй мэдээлэл бие биедээ өгөөд л нэг тардаг уламжлал дээрээсээ салахгүй л байгаад байна даа. Тэгээд өнөөдөр ярьж байгаа нь яг л нөгөө нэг өөр өөрийн чиглэлийн статистикуудаа яриад л нөгөө гэмт хэргийн тоо буурсан юм алга. Харин та нарын зүгээс бидэнд тавьсан асуудлууд бол шийдэгдсэн. 2017 оноос хойш хүүхэд хамгааллын төсөв хүрэхгүй байгаа учраас байдал хүнд байна төсвийг та нар шийдээд өгөөч гэсэн хүсэлтийг эмэгтэй гишүүдэд тавьсан. Тухайн үед З.Нарантуяа гишүүн бид 2 байсан. Би ажлын хэсгийг ахлаад Төсвийн байнгын хорооны ажлын хэсэгт ороод лобби бүлэг байгуулж байгаад 800 сая хүрэхгүй төгрөгийн зардалтай хүүхэд хамгааллын мөнгө орж ирж байхад эхлээд 5 тэрбум, дараа нь 2018 онд 6 тэрбум, 2019, 2020 онд бараг 8 тэрбум, одоо 10 орчим тэрбум төгрөг болчихоод явж байгаа.

Эдийн засаг амаргүй байх үед Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль амьдралд хэрэгжихэд санхүүжилтгүйгээр явахгүй. Нөгөө талаасаа хүүхэд хамгааллын зардал олон улсын жишгээр наад зах нь 11 тэрбум төгрөг байж үр дүнд хүрнэ гэж та бүхэн маань тооцоо судалгаа гаргаж өгсөн. Бид төсөвт суулгаад, өнөөдөр санхүүжилтийг шийдсэн.

Цагдаагийн байгууллагаас хүүхдийн байцаагчийн орон тоо чухал байна. Ядахдаа 100 гаруй хүүхдийн байцаагчийг төсөв мөнгөтэй нь шийдээд өгвөл болох гээд байна, хүний нөөц талаасаа, мэргэжилтэй хүн талаасаа, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх баг талаасаа хэрэгтэй байна гэх мэт асуудлууд бас тавьсан. Хууль зүйн сайдын багцад нь оруулж байгаад бид 130 хүүхдийн байцаагчийн орон тоо, санхүүжилтийг нь батлаад өгсөн. Өнөөдөр үзүүлж байгаа статистикаа та нар маань хар даа. Яг үнэнийг хэлэхэд буурсан зүйл алга. Тэгээд сая ХЭҮК орон нутагт төсөв байхгүй, мэргэжилтэн байхгүй, бүх байгууллагууд тус тусдаа ингээд дан ганц хүүхдийн юм хийгээд яваад байдаг юм байна гээд ярьж байна. Энэ бол шинэ мэдээлэл биш шүү дээ. Тийм ээ Х.Хунан дарга аа. Бид нар өнгөрсөн жил яг бас ингээд л сууж байсан. Яагаад та бүхэн маань нэгдэж 1 зорилгоор хүүхэд хамгааллынхаа асуудлыг багцлаад, энэ дээрээ тулгуурлаад шийдэл гаргаж болохгүй байгаад байна. Болохгүй байгаа бол тэр гол учрыг нь олоод явахгүй бол үнэхээр болохгүй байна шүү дээ. Тэгээд хамгийн гол нь энэ гарч байгаа статистик тоо баримт дээр, төсөв дээр суулгасан мөнгө, хүний нөөц талаас нь бид нар шийдээд байна. Одоо тэгээд дахиад энд орж ирээд бид нар яах вэ? Юу шийдэх гэж өнөөдөр орж ирж байна? Гэтэл хаалттай хаалганы цаана голчлон гэр бүлийн хүчирхийллийн асуудлууд, ялангуяа хүүхдийн хүчирхийллийн асуудал үйлдэгдээд байна шүү дээ.

Тийм учраас л бид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хуулиуд дээр нэлээд чангатгасан заалтууд оруулж байгаа. Бараг эрүүгийн шинжтэй, тэгэхдээ санкц хэт чанга болохоор энэ өөрөө бас нэг асуудлын шийдэл биш гэдэг талаас нь манай хуулийн салбарынхан хандаад байгаа. Бид ганц хүүхэдтэй ажиллах биш. Хүүхдийн арга хэмжээ авахдаа, хүүхдээ хамгаалахдаа гэр бүлтэй нь хамт тэр хүүхдийг тусгаарлах өрөөнд оруулах шаардлагатай байна. Эцэг эх, хамгаалдаг хүмүүстэй нь цуг ингэж асуудал дээр

хандахгүй бол хүүхдийг тусгай хамгаалалтын байранд байж байгаад буцаад 5 хоногийн дараа, 4 хоногийн дараа нөгөө л байдаг орчиндоо очно шүү дээ. Нөгөө л архи дарс уудаг, эсвэл нөгөө л хүчирхийлэл үйлддэг гэр бүлийнхээ орчинд очихоор давтагдана. Эцэстээ хүн амины асуудал, амь насаа алдах тохиолдол сая хөдөө орон нутагт гарлаа шүү дээ. Бүгдээрээ дараа жил дахиад суугаад хэлэлцмээргүй байна. Ажлын арга барилаа өөрчилмөөр байна. Ингээд баримт бичиг, төсөв мөнгөний тухайд бол хангалттай байгаад байна.

Би та нарт сая хэллээ. 2017 оноос хойш төсвийг нь бид яаж нэмэв? Өнөөдөр 10-11 орчим тэрбум төгрөг болтол хүний нөөцийн асуудал, нийгмийн ажилтны тухай сая ярьж байна. Тэрэнтэй бол санал нэг байна. Ер нь бид нар Боловсролын тухай хууль дээр, өмнө нь үдийн цайг үдийн хоол болгохтой холбоотой хууль дээр, ер нь хоол зүйч нийгмийн ажилтан 2 зайлшгүй сургууль бүхэнд байх ёстой. Гэхдээ нэгээр тогтохгүй байгаад тухайн хүүхдийн тоотой нь харьцуулсан байдлаар энэ орон тоо, төсөв мөнгөтэй нь шийдье гээд эхний алхмаар шийдээд явж байгаа.

Гэхдээ өнөөдөр 3000 хүүхдэд нэг нийгмийн ажилтан гэдэг бол яасан ч боломжгүй асуудал л даа. Тэгвэл одоо 2024 оны төсөв өргөн барих гэж байна. Та бүхэн маань ажлаа ХНХЯ-ан дээрээ нэгтгэж байгаад, нийгмийн ажилтныхаа тоог нэмэх, нэмэхдээ сургуулиудын хүүхдийн тоотой нэмээд, энэ нь өөрөө Боловсролын сайдын багц байх уу? Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад орох уу? гээд яг бодит шийдлээ хэлээд, асуудлаа шийдээд явмаар байна.

Яг үнэнийг хэлэхэд танин мэдэхүйн шинжтэй статистик мэдээллээр бие биеэ хангаад суух нь цаг үрэхийн л нэмэр болоод байна. Гэтэл та нар маань мэдэж байгаа хүүхэд хохирч байгаа асуудал үнэхээр буурахгүй байна.

Тиймээс би өнөөдөр асуулт асуухгүй. Харин одоо ажлаа нэгтгэе. Хаанаа төвлөрөх вэ, та нар энэ хурлын дараа бөөнөөрөө сууж байгаад энэ хоорондын уялдаа холбоогоо нэг болгомоор байна. Нэг шугамаар энэ хүүхэд хамгааллын ажил явдаг баймаар байна. Түүнээс тус тусдаа бүгд ярьж байна шүү дээ. Тэгэхээр чинь хаана ч үгүй юм болоод байна. Бүгд нэг л хүний, нэг л хүүхэд хамгаалъя гэдэг зорилготой байж байгаа бол ажлын уялдаа холбоогоо нэгтгэмээр байна. ХНХЯ уг нь зангидаад байгаа. Гэхдээ асуудал доголдолтой байгаад байна шүү дээ. Асуудал үүсэхээр нөгөө хэдэн гишүүд, эмэгтэй гишүүд хүүхэд хамгаалал руу хандуулахгүй байна гэдэг. Гэтэл үнэн хэрэгтээ сая та нар бас сонсож байгаа байх. Төсөв мөнгөнөөс эхлээд, хүний нөөц шийдээд л байдаг. Даанч бид нар тэнд очоод ямар та нартайгаа цуг суугаад хүүхэд хамгаалах ажиллах биш. Харин гүйцэтгэх засаглал, салбарын байгууллагууд тус тусын чиг үүргээ их сайн хиймээр байна.

Цаашдаа бид ажлын гүйцэтгэлтэй холбоотой Засгийн газрын 2022 оны бүх байгууллагуудын гүйцэтгэлийг авч үзэж байна. Ер нь яг амласан амлалт, хийе гээд төлөвлөсөн ажил, тэдгээрийн үр дүн гараагүй аудитаас сөрөг юм уу, хязгаарлагдмал гэсэн дүн авч байвал шууд хариуцлага тооцож байх ийм зүйл рүү орж байна. Тэгэхээр та нар маань бас ажилдаа дүгнэлт хийгээд өөрсдийнхөө ажлын уялдаа холбоог хангаад, бидний зүгээс яах вэ төсөв мөнгө хэлэлцэх юм уу,

хууль эрх зүйн актуудыг улам боловсронгуй болгох чиглэл дээр хамтраад ажиллаж байгаа. Гэхдээ та нарын маань санаа оноо чухал байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зарим нэмэлт оруулчихсан байгаа. Гэр бүлийн тухай хуулийг энэ намрын чуулганаар ХЗДХЯ, ХНХЯ өргөн барихаар ерөнхийдөө бэлэн болсныг бидэнд танилцуулсан. Хүүхэд хамгааллын хуульд дээр нэмэлт өөрчлөлт оруулаад санкцыг эрүүгийн чиглэлийн хатуу болгосон байгаа. Тэгээд эд нараа хэрэгжүүлээд бидний зүгээс та бүхэнтэйгээ хамтран ажиллаад явъя. Тэгээд жоохон үр дүнтэй ажиллах хэрэгтэй байна шүү гэдгийг л хэлье. Баярлалаа.

П.Анужин - Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн санал хэллээ. Одоо Ц.Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир - Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд асар олон байна. Энэ олон байгууллагуудын чиг үүрэг оролцоо ер нь ямар байгаа талаар хүүхдийн судалгаа хийж үзсэн үү?

Цагдаагийн байгууллага хэрхэн оролцоотой байна вэ? тэр оролцоогоо хангаж ажиллаж чиг үүргээ хэрэгжүүлж чадаж байна уу? Энэ олон давхардалтай хүүхдийн эрхийн чиглэлээр үндэсний газар, нийслэлийн газар, аймаг, дүүрэг, сум гээд л бүх шатанд байгаа. Төрийн, төрийн бус байгууллагуудын оролцоо гээд маш олон байгууллага хүүхдийн нэрийг барьсан, эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Бид нарт одоо хууль байгаа юу гэвэл байгаа. Бид нарт төсөв мөнгө байгаа юу гэвэл бас байгаа. Гэхдээ мэдээж учир дутагдалтай хязгаартай. Ер нь төсөв мөнгө нь хахцан гэдэг юм уу боломжтой салбар хаана ч байхгүй. Хэзээ ч төсөв санхүү хүрэлцээтэй гэж байдаггүй. Үе шаттайгаар нэмэгдүүлээд сайжруулаад явдаг. Бид нарт бүтэц зохион байгуулалт байгаа юу гэвэл байгаа. Гар хөл байгаа юу гэвэл байгаа. Гол нь энэ бүтэц зохион байгуулалтад төсөв санхүүгийн хуваарилалт яг эзнээ олж байна уу? Бүтэц нь яг зөвөөр ажиллаж чадаж байна уу? гэдэг чиглэлээр ер нь судалгаа хийсэн үү?

Би эндээс юуг харах гээд байгаа вэ гэвэл ерөөсөө энд оролцоотой байгууллагууд тодорхой кэйс гарлаа гэхэд шалгаад үзчихмээр байна. ХЭҮК нь яаж ажиллаж байна вэ? оролцоо нь ямар байна вэ? Хууль, эрх зүйн талаасаа хэр байна вэ? Одоо яам нь ямар байна вэ? Агентлаг нь ямар байна вэ? Газрууд нь ямар байна вэ гээд свот шинжилгээ хийгээд үзэхэд ер нь одоо аль байгууллага илүү түлхүү ач холбогдолтой байна, магадгүй шаардлагагүй гэдэг юм уу байгууллага байхыг үгүйсгэхгүй. Орон тоо байхыг үгүйсгэхгүй. Хүнд зориулсан орон тоонуудыг байгууллагуудын чиг үүрэг ач холбогдлыг гаргаад үзмээр байна.

Тэгвэл бид хаанаа төсөв мөнгөө илүү хуваарилах вэ? байгаа мөнгөө аль бүтцээ илүү сайжруулахад зарцуулах вэ? аль нэгжид хаана нь илүү асуудал

гараад байна вэ? гэдэг тэр талынхаа асуудлаар судалгаа хийгээд харчихвал зүгээр юм болов уу гэж бодож байна.

Хүүхдийн эрхийн чиглэлээр энэ цаг үед л жигтэйхэн асуудал гараад, мандаад, муудаад, эрх нь зөрчигдөөд байгаа асуудал биш. Хүүхдийн эрхийн, хүний эрхийн зөрчил хэзээ ч байсан, аль ч улсад байгаа. Тэгэхээр одоо л нийгэм нээлттэй болчихсон олон нийтийн сүлжээ ийм өргөн дэлгэр ашиглагддаг, мэдээ мэдээллийг маш хурдан өгөлцөж авалцдаг болчихсон, мэдээллүүдийг илүү түлхүү авдаг болсон учраас зөрчил нь харагдаад байгаа боловч бид нарын магтаж сайшааж ярьдаг социализмын үед ч гэсэн хүүхдийн эрхийн зөрчил хүний эрхийн зөрчил зөндөө л байсан. Тэр битгий хэл замын хүн айлд буугаад хүүхдийг нь өргүүлээд явуулчихдаг байсан юм байна лээ. Энэ хүний эрхийн, хүүхдийн эрхийн зөрчил мөн үү гэвэл мөн. Хүүхдүүдээ эрүүл мэндийг нь 100% хамгаалж чадаж байсан уу? Боловсролыг нь хамгаалж чадаж байсан уу? Сурах орчин нөхцөл боловсрол сурах эрхийг нь ингээд яриад байвал хүний эрхийн зөрчил хэзээ ч байхгүй болно гэж байхгүй.

Энэ өндөр хөгжсөн ардчилал ярьдаг, хүний эрх ярьдаг улс орнууд чинь ч гэсэн өнөөдөр хүний эрхийг хөсөр гээчихсэн гудамжинд хэвтээд л явж байгаа. Тэд нарыгаа харж хандаж чадахгүй болчихсон улс орнууд зөндөө л байгаа шүү дээ. Ер нь бол цаашдаа ч байна гэж би бол хувьдаа хардаг. Харин би юу гэж харж байгаа вэ гэхээр манай энэ бүтэц зохион байгуулалт тодорхой нэг кэйс гарахад маш хурдан маш уян хатан арга хэмжээг авч урьдчилан сэргийлэх, эсхүл таслан сэргийлэх арга хэмжээг авч чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр л асуудлын гол нь байгаа юм. Асуудал нь шийдэгддэггүй, хэн нэгэн дээр очоод гацчихаж байгаа юм. Хэнээс болсон юм, тэр цаад эзэнд нь хариуцлагыг нь оногдуулж чадаж байна уу? тодорхой кэйс дээр маш хурдан арга хэмжээг авч чадаж байна уу?

Манай одоогийн энэ бүтэц зохион байгуулалт хууль эрх зүйн зүгээс юунд нь гацаад тээг саад болж байна. Төсөв хөрөнгийн юу нь хаана нь дутагдалтай байдал гарч ирж байна гэдэг энэ юмыг л одоо цаашдаа бол бид нар энэ бүтэц зохион байгуулалтуудыг хийнэ. Түүнээс одоо бид ирээдүйд хүний эрхийг хамгаална гээд урьдчилж хараад ирээдүйд үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлээд явна гэдэг бол их амаргүй. Энэ цаг үед ер нь бол дэргэдээ байгаа гэртээ байгаа өөрсдийнхөө хүүхдүүдийг хүртэл юу бодож санаж явдаг юм, юунд орооцолдож явж байгааг эцэг, эхчүүд бид мэдэхгүй байгаа шүү дээ. Тэгтэл хүний хүүхдийн төлөө, бусдын төлөө маргааш юу үүсэхээр байна вэ? Нөгөөдөр юу үүсэхээр байна вэ? Нийгэм хаашаа явж байна вэ? Хүүхдийн сэтгэл зүй ямар байна вэ? гэдгийг бид нар урьдчилж тооцоолж тэрийг хамгаална гэж ярина гэдэг бол нэлээн төвөгтэй асуудал болов уу.

Тийм учраас би өнөөдөр яг асуудал юун дээр үүсэж байна түүнд манай хүүхдийн эрхийн чиглэлээрх энэ байгууллагууд хэр уян хатан, түргэн шуурхай ажиллаж арга хэмжээг авч чадаж байна вэ гэдэг энэ чиглэлээр л дүгнэлт хийж, харж, ажиллах нь илүү юм болов уу гэж бодож байна.

Тухайлбал, сая Ганданд үүссэн тэр хүүхдийн эрхийн зөрчил гээд л асуудал

байна. Өнөөдөр ямар арга хэмжээ авсан бэ? Одоо ингээд л хэд хоног шуугиад л тасарна. ХЭҮК-оос нэг шалгалт хийж байна гэсэн. Өнөөдөр ямар арга хэмжээ авсан, хүний эрхийн, хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаатай байгууллагууд яаж ажилласан, өнөөдөр хүүхдүүдийн нэр хүнд, сэтгэл зүй ямар байна, ямар түвшинд оччихсон байна вэ? Нийгэмд яаж ганцаардлыг бий болгох асуудал, нэр хүндийн асуудал, аав ээжийнх нь нэр хүндийн асуудал гээд энэ байгууллагууд оролцож чадаж байна уу? Аль дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аль хүүхдийн байгууллагууд энэ кэйс дээр ажиллаж байна вэ? Ажиллах ёстой энэ чиг үүргээрээ одоо ажиллаж чадаж байна уу, үгүй юү? Оролцож чадаж байна уу, үгүй юү? Тэгээд л доор нь ингээд шалтаг шалтгааныг нь тодорхойлоод, холбогдох эзэнд нь хариуцлагыг нь үүрүүлээд л явах нь өөрөө хүүхдийн эрхийг хангуулах чиглэлээр манай байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг юм болов уу гэж би хувьдаа боддог.

Таслан сэргийлж чадаж байна, арга хэмжээгээ авч оногдуулж чадаж байна. Хүүхдийн эрхийн зөрчлийг арилгаж байна. Тэгэхгүй болохоор ингээд нэг кэйс гардаг. Тэрэн дээр төр засгийг буруутгаад, яамдыг буруутгаад, агентлагийг буруутгаад, эцэг эхийг буруутгаад ерөөсөө буруутныг хайгаад л байдаг. Нэгэнт кэйс гарчихлаа. Энэ кэйс дээр яаж ажиллах юм хуулийн хүрээнд нэгдсэн байдлаар яаж олон байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангаж ажилладаг юм, хэн хангаж ажиллах ёстой юм. Аливаа кэйс дээр Цагдаагийн байгууллагаас нь, сэтгэл зүйчдээс нь, дүүргээс нь одоо тэгээд бүх л байгууллагууд оролцох ёстой байлгүй дээ. Хүнээр бол гарын 10 хуруу нь тэгш ажиллах ёстой. Түүнээс биш зөвхөн цагдаагийн байгууллагын эсхүл зөвхөн ХЭҮК-ын үүрэг биш шүү дээ.

Хүүхдийн эрхийн асуудал яривал Засгийн газрын бүх яам, агентлагуудтай холбоотой асуудал үүсэж байгаа шүү дээ. Ер нь бол яам өөрсдийнхөө чиглэлээр энэ кэйс дээр манай зүгээс яах ёстой билээ юун дээр нь манай яамны дутагдал гарч байна вэ гэдгийг л олж харж байх ёстой. Түүн дээр л асуудлаа ярьж холбогдох хуулиуддаа өөрчлөлт оруулах, сайжруулах шаардлагатай байгаа юм. Ер нь бол ингээд ойр ойрхон уулзаад уламжлалт уулзалтуудаа хийж цаг үеийн асуудлуудыг ярилцаж, хүний эрхийн зөрчлийн асуудлыг байнга тогтмол ярьдаг байх ёстой. Ингээд нэг тоо баримтууд чинь зүгээр гараад ирчихсэн асуудал биш шүү дээ. Өсөлт бууралт, авсан арга хэмжээнүүдийн ажлын тайлангууд зэрэг дээрээ дүгнэлт хийгээд одоо яах вэ? Хууль зүйн талаас нь яах вэ? Ирэх жилийн төсөв мөнгөн дээр нь яах вэ? Хаана нь нэмэгдүүлэх вэ? Ингээд байнга тогтмол энэ уулзалт хурал, тайлан, сонсгол, ярьж хэлэлцэж байх ёстой. Үнэхээр хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг энэ олон байгууллагууд тэгж байж бид нар алдаа оноогоо энд ярихгүй бол өөр хаана ярих юм, хэн ярих юм. Зүгээр нэг одоо Төрийн бус байгууллага яриад явах юм уу эсвэл зүгээр ХЭҮК яриад явах юм уу гэдэг ийм асуудал байгаа. Хүний эрхийн зөрчил мөнхийн байна. Бид бүхэн 100% таслан зогсоогоод цаашдаа хэзээ ч гарахгүй гэж худлаа яриад яах вэ.

Тийм учраас энэ салбарын гол хороо болох Нийгмийн бодлогын байнгын хороо дээрээ энэ асуудлуудыг ярьж байх ёстой. Ингэж ярьж байна гэдэг чинь бид нар асуудлуудаа ярьж байна, үнэлэлт дүгнэлт өгч байна, бие биеэ сонсож байна,

анхаарлаа хандуулж байна. Бас үүний цаана дараа дараагийн төсөв хөрөнгө батлах асуудал дээр хууль тогтоогч нар хөрөнгө мөнгө хуваарилах төсвийн захиран зарцуулагч нар төсөв мөнгө хуваарилах асуудлууд бүгд уялдаатай явна шүү дээ. Ингэж ярихгүй бол энийг хэн ч ярихгүй. Ярьсны үр дүнд өнгөрсөн хугацаанд төрийн бус байгууллагууд, яамнаас тодорхой ахиц дэвшлүүд санал санаачилга гарч байна. Төсөв мөнгөн дээр ингэдэг болсон, орон тоог ингэж сайжруулсан, ингэж цалин мөнгийг нь нэмэгдүүлсэн. Энэ чинь нэг том алхам. Ярьсны үр дүнд л ингэж дэвшил гарч байгаа гэж би хувьдаа харж байгаа.

Б.Жаргалмаа - Ц.Сандаг-Очир гишүүндээ баярлалаа. Хяналтын сонсголын дэгийг танилцуулсан, асуултаа 2 хоногийн өмнө бичгээр ирүүлнэ гэсний дагуу одоогоор 3 асуулт ирсэн байна.

Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй бөгөөд Нийтийн сонсголын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ гэсэн байна. Улсын Их Хуралд Нийгмийн бодлогын байнгын хороонд үг хэлж байгаа гэдгээ ойлгоорой.

Б.Арсланбат - Би боловсролын байгууллагад 50 гаруй жил ажиллаж байгаа. Энд бол хүүхэд хөгжил, хамгааллын тухай ярьж байна. П.Анужин гишүүн ярьсан. Тэр хөндөж болохгүй юм гэж байдаг. Боловсролын байгууллагууд уруугаа хөндсөн, хүүхдийн зусланг хөндсөн, хүүхдийн хичээлийн дараах хүмүүжил хамгааллын хөгжлийн ажил, ижий аавыг амраах зорилгоор хүүхдийн зуслан байгуулагдсан байдаг. Хүүхдийн зусланг бол ерөөсөө хувьчлаад дуусчихсан. Одоо би “Анар” гэдэг жижигхэн зуслан байгуулаад ажиллаж байна. Энд бол манай хүүхдийн агентлаг, Нийслэлийн хүүхдийн газраас дэмжээд асран хамгаалагчтай хөгжлийн бэрхшээлтэй 270 хүүхэд амраалаа. Тэгэхэд 29 дүгээр сургуулийн хөлгүй, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн мөнгийг нь одоо болтол Хөдөлмөр нийгмийн хамгааллын дүүргийн хэлтэс өгөхгүй байна. Та нарын яриад байгаа зүйлүүд чинь тэр доор гацаагаад байна. Ээж аавыг нь очихоор өчнөөн бичиг баримт нэхээд хүүхдийг нь би амраачихаад явуулдаг, хөрсөн дээрээ өгдөггүй, ийм юм болж байна.

Хоёрдугаарт зуслангийн захирлууд өчнөөн бичиг баримт явуулсан. Тийм учраас би өнөөдөр энд яагаад гараа өргөөд, ингээд уухилаад байна гэхээр олон гишүүн байгаа дээр сонсгоё гэсэн юм. Энэ зусланг хувьчилснаас хойш яг жинхэнэ гардан ажиллаж байгаа хүмүүсийн хүүхдийн бүх зуслангуудыг хоморголон газрын төлбөр авдаг болсон. Хүүхдийн эрхийн конвенцод төрөөс хүүхдийн төлөө ажил, үйлчилгээ явуулж байгаа бүх газруудад тусламж үзүүлнэ. Тэр дундаа сургууль, цэцэрлэг, зуслангуудын төлбөр авахгүй гэсэн одоо авч байгаа. Энэ тал дээр анхаарч өгөөч гэж хэлмээр байна.

Мөн ерөнхий боловсролын сургууль, хувийн сургуулиудад хувьсах зардал өгдөг. Зуслангуудад өгдөггүй. Бид их мөнгө нэхэхгүй 20 сая юм уу, 30 саяыг нэхнэ. Тэрийг нь аваачаад 500 саяын барилга байшин барьчихаж чадна. Өгөхгүй байна, дэмжихгүй байна.

Хэн очиж тэнд хөгжих юм, хэн очиж хамгаалуулах юм хүүхэд л очно. Энийг олон гишүүн байгаа дээрээ ороод хэлээч. Ноднин, уржнан явсан газрын багц хууль хэлээлцэж байна. Чиний газар хүлээж бай гэсэн. Одоо Налайхын газрын алба Тэрэлжийн зуслангуудаас маш их мөнгө нэхэж байгаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг хөгжүүлэх төлөвшүүлэх энэ ажлаа дэмжиж байгаа төр засаг биш болоод байна. Энэ дээрээ анхаараач. Өөр нэг юм нь Хөдөлмөр нийгмийн халамжийн дүүргийн хэлтсүүддээ анхаарал тавьж, хэлж өгөөч. Үнэндээ хэцүү, өрөвдмөөр. Би л хэнхэгтэйгээрээ явж хүүхдүүдийг нь сургуулиас хамж авчихаад амрааж байна. Тэгээд мөнгийг нь өгдөггүй. 550000 төгрөгийн 275000 төгрөгийг нь ээж аав нь төлчихөөд очсон, хоёулаа хараа байхгүй, хүүхэд нь очиж мөнгөө авъя гэсэн чинь Дарханы Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар хувьсах зардлын баримтыг нь аваад ир гэж байна. Мөнгөө тушаачхаад очсон хүүхдийг явуулж байгаа шалгалтаанаа гаргаж ирээч. Ерөөсөө л ингээд дунд нь хаячихдаг. Тийм баймааргүй байна. Ажил хийж байгаа улсуудаа оновчтойгоор дэмжиж баймаар байна.

Б.Жаргалмаа – Б.Арсланбат гуай танд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ зусланд амраах үйл ажиллагаа зохион байгуулж байгаад баярлалаа. Бид нар нийгмийн даатгалын багц хуульдаа тодорхой хэмжээний өөрчлөлт оруулаад байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдийнхээ асрамж халамжийн мөнгийг нэмэх хуулийн зохицуулалт хийгдээд явж байгаа гэдгийг бас танилцуулъя. Яг өнөөдрийн байдлаар хүүхдийн зусланд амраах талаар ямарваа нэгэн байдлаар зохицуулагдаагүй гэдгийг танд бас хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Улсын Их Хурлын чуулган 15 цагаас зарлагдсан байгаа. Энэ 7 хоногт Улсын Их Хурлын чуулган хуралдаад завсарлах хугацаа нь болсон учраас бид нар бас амжиж асуудлуудаа шийдвэрлэх, яаралтай хуралдаанууд зарлагдаж байгаа тул гишүүд хурлынхаа ирцдээ орохоор гарсныг та нартаа дуулгая.

За одоо Д.Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут - Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Чухал асуудал хөндөж ярьж байгаад их талархалтай байна. Ц.Идэрбат гишүүн төрийн байгууллагуудын зовлон жаргалтай холбоотой асуудлыг нэлээн хөндсөн. Ярьж байгаа зүйлтэй бол санал нэг байгаа.

Бид нар энэ хүүхдийн эрхийг хамгаалах тал дээр дорвитой өөрчлөлтүүдийг хийхийн тулд төр тодорхой хэмжээгээр анхаарах ёстой, нөгөө талдаа олон нийтийн оролцоог бүрэн дүүрэн хангадаг байх ёстой. Гэхдээ зөвхөн энэ асуудал дээр биш нийгэм бүхэлдээ өөрөө хариуцлагатай, тодорхой шийдэлтэй, тодорхой үр дүнтэй байх ёстой гэж харж байгаа.

Бид нарт гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо гээд маш олон мэдээллүүд байна л даа. Амь насаа хорлосон байна, хүчирхийлэлд өртсөн байна, гэмт хэрэгт

холбогдсон байна, гэнэтийн осол аюулд өртсөн байна гээд. За энэ дундаасаа бол нэлээн нийтлэг байгаа асуудлууд нь юу вэ гэхээр амиа хорлолт, хүүхдийн эрхийн асуудлууд байна. Магадгүй тэр орон гэрээсээ өдөр болгон сэтгэл зүйн хувьд дарамтад ордог нөхцөл байдлууд байнгын байдаг. Өнөөдөр зөвхөн хүүхэд хамгаалах төвөөр ч гэдэг юм уу дамжуулаад ажил хэрэг явуулаад байгаа нь хязгаарлагдмал зүйл гэж хардаг. Энэ асуудлын уг үндсийг олохгүйгээр бас уг үндсийг олоод тэрэн дээр шийдэл гаргахгүйгээр цаашаа явахгүй. Ямар ч үр дүн гарахгүй, гал унтраах төдий л юм болоод байгаа.

Нэг ёсондоо нэг хүүхдийн эрх зөрчигдлөө, аав ээж нь асуудал гаргалаа гээд тэр хүүхэд хамгаалах төв дээр хэд хонуулаад буцаагаад гэрт нь өгч байгаа. Яг үндсэндээ асуудал шийдэгдсэн үү гэвэл шийдэгдээгүй. Тийм учраас бид энэ хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр яаж ажиллах ёстой вэ гэдгээ сайн тодорхойлох хэрэгтэй.

Төрийн байгууллагууд хоорондоо ажлын ямар уялдаа холбоо гаргаж ажиллах вэ гэдэг дээр анхаарах ёстой гэж бодож байна. Санхүүгийн асуудал байгаа нь үнэн. Гэхдээ төрийн байгууллагуудын өөр хоорондын зохицуулалтуудаар хийгдэх маш олон ажлууд байгаа. Бүтэц маань ч гэсэн төдийлөн бид нарт хангалттай бус байгаа. Аав ээж нь яагаад архи уугаад байгаа юм бэ гэдэг шалтгааныг олохын тулд бид ажиллах ёстой. Шалтгааныг тогтоогоод түүнд чиглэсэн алхмуудыг хийхгүйгээр ямар нэгэн үр дүн, өөрчлөлт гарахгүй, байхгүй. Үүсч байгаа шалтгааныг одоо олж тогтоогоод цаашид гаргахгүй байх зорилготой ажил хийхгүйгээр энэ маань үр дүнгүй болно. Тийм учраас тодорхой бүтэц хэрэгтэй, тодорхой санхүүжилт хэрэгтэй, тодорхой үйл ажиллагаа, зохион байгуулах хэрэгтэй байгаа.

Үнэндээ одоо бид ингэж чадаж байна уу, гэвэл бас төдийлөн чадахгүй байгаа. Бидний төсөв мөнгө хүрэлцээгүй байгаа, бүтэц нь тийм тодорхой биш байгаа учраас тэд энэ асуудал дээр ажиллаж байсан туршлага байна уу? гэдэг дээр надад нэг хариулт өгөөрэй. Аав ээж нь архи уугаад, үр хүүхдүүдээ дарамталдаг, тэнд хамт байх амьдрах нөхцөлгүй болчихсон. Байсан бол тэр аав ээжтэй ажиллаад архинаас гаргадаг ч юм уу, учир шалтгааныг нь олоод ажилд оруулдаг, нийгэмшүүлэх арга хэмжээнүүд авсан тийм кэйс байна уу? Ингэснээр тэр гэр бүл илүү сайхан амьдрах нөхцөл бололцоо нь бүрдчихсэн, хүүхэд нь одоо гэртээ амар тайван амьдарч байгаа тийм дүр төрх байна уу? Бид ийм л үр дүн гаргах ёстой, ингэж чиглэж ажиллах ёстой гэж харж байгаа. Үүний тулд бид нарт ямар арга ажиллагаа шаардлагатай байгаа юм бэ? Бид нарт юу хэрэгтэй байгаа юм бэ? ХНХЯ энэ дээр нэг хариулт өгөөч ээ. Тэгэхгүйгээр бид нар ингээд гал унтраах ажил хийгээд байгаа байхгүй юу.

Магадгүй энэ нэг баригдмал байдал, төсөв хөрөнгө, хүний нөөцтэй холбоотой асуудал байгаа. Тэгэхээр бид нар бүрэн дүүрэн хүрч ажиллахын тулд яах ёстой вэ гэдэг дээр юуг анхаарах шаардлагатай байна вэ? Одоо ямар шийдлүүд байгаа юм бэ? Ямар шаардлага байгаа юм? Шийдэл гаргахад Нийгмийн бодлогын байнгын хорооны ч юм уу, цаашлаад Улсын Их Хурлын гишүүдээс

дэмжлэг авах, ямар асуудал байгаа вэ гэдгээ Та бүхэн бүр тодорхой болгож хэлмээр байгаа юм.

Хүүхдийн амиа хорлолттой холбоотой асуудлууд нэлээн үүсэж байсан учраас боловсролын байгууллагууд дээр сэтгэл зүйчид ажиллаад эхэлчихсэн. Энэ бол нэг талдаа том давуу тал болсон. Яг үнэндээ тэр сэтгэл зүйчдийг бол Орхон аймгаас эхэлсэн. Тэд нар бол маш сайн ажилладаг. Хүүхдүүд бас өөрсдийнхөө жаргал зовлонг маш сайн ярьдаг юм байна лээ. Бид нар учир шалтгааныг нь тогтоон, цаашлаад шалтгаан нөхцөлийг устгах, алга болгох чиглэл рүү харж ажиллах хэрэгтэй байна. Тэгэхээр энэ дээр манайхан цаашдаа ямар зүйл төлөвлөж байгаа юм бэ гэдэг дээр нь хариулт авъя.

Хоёр дахь нь **АСАП** санд бүртгэлтэй байгаа талаар мэдээлэл өгсөн байна. Хүүхэд хүчирхийлсэн, хүчиндсэн 10 хэдэн хүний асуудал гэж ярьж байна. Эндээс 9 хүн нь гадаадад гараад явчихсан. Тэгээд эд нарын хойноос манай хууль хяналтын байгууллагууд ажиллаж байгаа юм уу? Би бол нийгмийн үнэт капиталыг хүн гэж харж байгаа. Мөнгө төгрөг биш. Тэр мөнгө төгрөгийг яах вэ хүн бий болгодог. Тэгэхээр манайхан болохоор Хөгжлийн банк ч юм уу, янз бүрийн асуудал гараад л хулгай зэлгий гэж яриад л тэгээд тэрэнтэй холбоотой асуудалд нийгмээрээ давлагаалчихдаг. Тэгээд дээр нь манай хууль хяналтынхан шувуу ажиллагаа энэ тэр гээд ингээд зохион байгуулалт хийгээд явж байгаа.

Яагаад энэ нийгмийн үнэт капитал болсон хүүхдийн асуудал эрх хөндөгдчихөөд түүнтэй холбоотой асуудлууд нь тодорхой болчихсон, оргон зайлчихсан байхад Хууль хяналтын байгууллага энэ тал дээр ажиллахгүй байгаа юм бэ? Магадгүй тэр шувуу ажиллагаа чинь энэ дээр илүү хүчтэй явах ёстой гэж харж байна. Бид ирээдүй болсон нийгмийн баталгаа, үнэт капиталгаа хайрлаж хамгаалахгүйгээр асуудлын хойноос хөөцөлдөнө гэдэг бол бас утгагүй зүйл байхгүй юу. Энэ дээр ер нь ямар ажиллагаа зохион байгуулж байна вэ?

Эцсийн бүлэгт хамгийн чухал асуудал бол нийгмийн соён гэгээрэлтэй холбоотой асуудлыг маш өндөр түвшинд хийж чадаж байж, нийгэмд өрнөж байгаа, болж бүтэхгүй бүхий л зүйл аажимдаа алга болно.

Үүнийг хийхийн тулд бид яаж ажиллах ёстой юм бэ? Төрийн бүхий л шатны байгууллагууд, хувийн хэвшлийнхэнтэй ажиллах хэрэгтэй. Иргэдийг мотивацжуулж, идэвхжүүлж хөдөлгөөнд оруулж байх хэрэгтэй. Зөвхөн хүүхэд хамгааллын чиглэлээр гэхээс илүүтэй нийгмийн бүхий л салбар дээр, өдөөлтийн чиглэлийн үйл ажиллагаануудыг түлхүү авч хэрэгжүүлж байх хэрэгтэй юм. Ингэж байж энэ нийгэм чинь өөрөө мэдээ мэдээлэлтэй болдог. Мэдээ мэдээллээсээ улбаалсан нийгмийн идэвхжилтүүд явагддаг. Ингэж байж цаашдаа нөгөө үр дүнгүүд гарна. Тэгэхээр энэ дээр манай холбогдох байгууллагуудын хувьд яг яаж ажилласан юм бэ? Өнгөрсөн хугацаанд нийгмийн соён гэгээрлийг бий болгохтой холбоотой, нийгэмд мэдээлэл түгээхтэй холбоотой асуудал, тэр хүмүүсийг мэдээллээр хангаад тэр хүмүүсээс гарч байгаа үр дүнг яаж тодорхойлж гаргаж ирж байна вэ? Бид яг энийг хийж чадаж байна уу, үгүй юу. Мэдэхгүйн зовлон монголчуудад маш их байгаа. Бүхий л салбар

дээр мэдээллийн хомс байдал далимдуулсан тодорхой нэг асуудлууд гарч байгаа. Мэдээ мэдээлэлгүйгээс болоод нийгэмшиж чадахгүй, өөртөө авах боломжуудаа алдчихсан, амьдрал ахуй нь хүнд болсон, түүнээс болсон сөрөг үр дүнгүүд гараад эхэлчихсэн ийм л дүр зургууд байгаа. Энэ асуултууд дээр хариулт авъя.

Б.Жаргалмаа - Баярлалаа. Д.Батлут гишүүний асуултад ХНХЯ, Хууль зүй, дотоод хэргийн яам (цаашид "ХЗДХЯ"-гэх)-наас хариулт өгөх үү? Мөн ЦЕГ-аас гишүүний асуултад хариулъя.

Н.Баярмаа - Д.Батлут гишүүний асуулт болон Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Хүүхдийн байгууллага тогтолцоо хууль тогтоомждоо үнэлгээ хийсэн үү, хэчнээн хууль тогтоомж бүх асуудлыг шийдээд байгаа ч гэсэн хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурахгүй байна гэж үнэхээр та бүхний маань хэлж байгаа үнэн. Тэгэхээр ХНХЯ-аас 2020 онд Хүүхдийн эрхийн тухай хуульдаа үнэлгээ хийсэн. Хүүхэд хамгааллын хуульд үнэлгээ хийсэн. Хүүхэд хамгааллын энэ олон хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй тогтолцоо чинь ажиллаж байна уу, үгүй юу гэдэг дээр бид нар бас хүүхэд хамгааллын компакт гэрээг АНУ-ын төрийн департаменттай хамтран хэрэгжүүлж байгаа. Үнэлгээгээр хууль, эрх зүйн хувьд бол бид нар шинэчлэх шаардлагатай байна. Хүүхдийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрсдэлийг нь тогтоох асуудал дээр ХНХЯ ажиллаад байна.

Хүүхдийг гэмт хэрэгт өртөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхэд хамгаалах асуудал бол ХЗДХЯ дээр байна. Нөгөө талаараа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд анх хүүхэд хамгааллын чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг батлагдсан. Хүүхэд хамгааллын асуудалд хамтарсан багийг одоо Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тусгаад Хүүхэд хамгааллын хуулиас хассанаараа энэ хууль тогтоомжийн хувьд хоёрдмол байдалтай болгосон байна. Хүүхдийн байгууллага мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах юм шиг нэг талдаа, нөгөө талдаа орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хангах юм шиг тусгасан, санхүүжилт нь болохоороо орон нутгийн төсвөөсөө хамтарсан багийн болон нэг цэгийн үйлчилгээний санхүүжилт гарах ёстой. Санхүүжилтийн хувьд, бодлого зохицуулалтын хувьд, хууль, эрх зүйн хувьд нь хоёрдмол байдалтай болгосон байна. Ийм учраас хууль, эрх зүйн орчноо өөрчлөх шаардлагатай байна гэсэн дүгнэлт гарсан. Тэгээд энэ дүгнэлт дээр уялдуулаад бид Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хуралд өргөн барихаар бэлэн болчихсон байж байна.

Мөн бид 2021 оны Төсвийн хуулийг дагуулж Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хүүхэд хамгааллын үйлчилгээ гэж юу юм бэ гэдгээ тодорхойлсон үйлчилгээний журамтай болсон. Энэ дагуу үйлчилгээ үзүүлэх зардлыг эмэгтэй гишүүдийн санаачилгаар бий болсон. Энэ 8 тэрбум төгрөг бол Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар буюу агентлагт 46% нь, аймаг, нийслэлдээ 20 хэдэн хувь нь, яаманд 6% нь гээд байгууллагуудад төвлөрсөн. Энэ зардлыг

хүүхдэдээ өгөх үйлчилгээ үзүүлбэ, гэр бүлд нь үзүүлбэ, хамтарсан багт нь шилжүүлбэ, нэг цэгийн үйлчилгээнд нь шилжүүлбэ гээд 350 нийгмийн ажилтнуудынхаа дунд яг энэ кэйс дээр ажилладаг цаг хугацаан дээр нь тулгуурлаж судалгаа хийсэн. Хүүхдийн хүчирхийллийн төрөл хэлбэрээрээ үзүүлдэг үйлчилгээ нь өөр өөр байдаг. Тэгэхээр энэ үйлчилгээгээр нь бид нар гэр бүлийн орчинд хамтарсан баг ямар үйлчилгээ үзүүлэх юм бэ? Гэдэгт тулгуурлаад хувьсах зардалдаа нөхцөл байдлын үнэлгээ хийхэд нэг хүүхдийн 43800 төгрөг зарцуулж байна. Нэг цэгийн үйлчилгээ буюу төрийн хамгааллын байранд бэлгийн хүчирхийлэл буюу бэлгийн зүй бус хандлагад өртсөн хүүхдэд 6 сараас 3 жилийн хугацаанд үйлчилгээ үзүүлдэг юм байна. Дундаж хугацаагаар нь аваад үзвэл 4,000,976 мянган төгрөгийн зардал гарах тоо гарсан. Хүүхэд хамгааллын үйлчилгээний болон төсвийн шинэчлэлийг хийгээд, цахимжуулаад хянаад явж байна. Гэхдээ энийгээ цаашид илүү сайжруулахын тулд үнэхээр саяын хэлж байгаа хүний нөөцийн асуудалтай холбогдуулаад Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулга дээр хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтнаас эхлээд Төрийн захиргааны төв байгууллага хүртэлх энэ эрх зүйн зохицуулалт нөгөө талдаа энэ үйлчилгээ үзүүлэх кэйс менежментийн асуудлуудыг оруулж ирж байгаа.

Хүүхэд хамгааллын санхүүжилтийн асуудлыг ганцхан хүүхдийн байгууллага төвлөрдөг биш. Үнэхээр энэ боловсролын орчинд үйлчилгээ үзүүлж байгаа сургууль, сургалтын орчин, дотуур байр, сүм хийдийн дэргэдэх дотуур байрны асуудал, нийгмийн ажилтны үйлчилгээ үзүүлэх зардлыг Боловсролын сайд маань өөрөө төсөвтөө төлөвлөөд явдаг. Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны зардлыг мөн хууль зүй болон прокурорын байгууллага маань төсөвлөөд явдаг. Ингээд удахгүй бас Улсын Их Хуралд өргөн барина.

Хүний нөөцийн судалгаа гарсан. Хуучин Хүүхдийн төлөө үндэсний газар гэж байгуулагдаад ажиллаж байсан. 2016 оноос хойш дээр нь нэмэгдээд гэр бүлийн асуудал, залуучуудын асуудал гээд улсын хэмжээнд яг хүүхдийн асуудал хариуцсан 1054 хүн байгаагаас яаманд 10 хүн, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт 41 хүн, аймаг дүүрэгтээ 728 хүн ажилладаг. Шинээр болсон бүтэц гэх юм бол хүүхдийн тусламжийн утасны төв дээр 25 хүн, түр хамгаалах байран дээр 20 хэдэн хүн нийт 40 хэдэн хүн л нэмэгдсэн. Тэгээд хүний нөөцийн хувьд бол хуучин байгаа хүүхдийн байгууллага дээр энэ олон чиг үүрэг энэ ажлууд яасан байна? Хүний нөөцийн хувьд бол учир дутагдалтай гэсэн. Тэгэхээр одоо анхан, дунд шатандаа бид Сангийн яамтай ярьж байгаад энэ хууль батлагдвал сум, хороо болгонд ажиллах 534 нийгмийн ажилтан 2024 оноос ажиллах нөхцөл бололцоотой болсон гэж үзэж байгаа.

Б.Жаргалмаа - Н.Баярмаа дарга товчхон яриарай. Тэгэхгүй бол бусад хариултаа авч чадахгүй байна.

Н.Баярмаа - Кэйсийн асуудал дээр бол мэдээж манайхан 2016 оноос эхлээд хамтарсан багт 765 хүн жилдээ 4000-7000 кэйс дээр ажилладаг. Одоо кэйс шийдвэрлэлтийн хувьд бол 52%-тай гэсэн үнэлгээ байгаа.

Б.Жаргалмаа - ЦЕГ 9 холбогдогч оргон зайлсан талаарх асуултад хариулъя.

Г.Мөнхбаяр – ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга цагдаагийн хошууч Мөнхбаяр байна. Цагдаагийн байгууллагаас энэ хүүхэд хамгааллын чиглэлээр яг одоо үндсэн чиг үүрэгт дагнасан нэгжийг байгуулан 2021 оноос Засгийн газарт холбогдох саналуудаа ХЗДХЯ-аар уламжлан нийтдээ 103 орон тоог бол шийдвэрлэсэн. 103 орон тоог шийдвэрлэснээрээ ямар үр дүн гараад байгаа юм бэ гэвэл үндсэндээ манай нэг эрүүгийн мөрдөгч буюу мөрдөгч нарын гар дээрх ачаалал бол нэг сардаа ойролцоогоор 70-аас 80 гэмт хэрэг байдаг. Тухайн чиг үүрэг бүхий алба хаагчдыг томилсноороо яг энэ төрлийн нуугдмал гэмт хэргүүдийн илрэлт, илрүүлэлтийн явц нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор цагдаагийн байгууллагад эрэн сурвалжилсан. **АСАП** санд бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг шалгагдах явцдаа оргон зайлсан 9 холбогдогчийг прокурорын байгууллагад холбогдох саналуудаа өгөөд прокурорын хяналтад, шүүхэд шилжүүлэх саналтай явж байх хугацаанд оргон зайлсан байгаа.

Тухайн 9 иргэн дээр Интерполын үндэсний товчооны ажлын албанд хандан бид бүхэн олон улсад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу хандчихсан, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулсан. Ингээд 2 хүнийг одоогоор илрүүлээд олж тогтоочихсон байна. Мөн нийтдээ ерөнхий болон тусгай арга хэмжээг бол хүүхэд хамгааллын чиглэлээр цагдаагийн байгууллагаас тасралтгүй холбогдох яам агентлагуудтайгаа зохион байгуулж явуулдаг. Үүний дүнд гэмт хэргийн хохирогч болсон 52 хүүхдийг эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучилсан. Ингээд 32 хүүхдэд аюулгүй байдлын хамгаалалтыг биечилсэн байдлаар зохион байгуулаад ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ цагдаагийн байгууллага яг дагнасан чиг үүрэгтэй алба хаагчдын орон тоог нэмснээрээ энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт ахиц бол одоо гарч байгааг тооцож болно.

Б.Жаргалмаа - **Г.Мөнхбаярт** баярлалаа. **Д.Батлут** гишүүн

Д.Батлут - Бүгдээрээ энд нэг их тийм гоё юм ярьж, тоон мэдээлэл яриад яах вэ, гарц яримаар байгаа юм. Тоон мэдээллүүд чинь ямархуу байдлаар нэгтгэгдэж энд ирдгийг ч би бас гадарлана. Орон нутагт ажиллаж байсан учраас тодорхой саналтай байгаа юм. Та нар орон нутгийн төсөв дээр хүүхэд хамгааллын чиглэлээр мөнгө тавигдахгүй байна гээд байгаа. Орлого бүрдүүлдэг 5-6 аймаг байдаг юм. Бусад аймаг нь дандаа татаастай амьдардаг. Тэгээд аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгч гэж хэдэн хүн нь болохоор тойрог дээрээ мөнгө тавих гээд хөрөнгө оруулалт гээд баахан ярьдаг. Тэр Засаг дарга, Хурлын дарга нарын зовлон их байдаг байхгүй юу.

Бид нарт ямар гарц байгаа вэ гэвэл орон нутгийн төсвийн тэдэн хувийг хүүхэд хамгааллын зардалд зарцуулна гээд хуульчлаад өгчих хэрэгтэй. Иймэрхүү

байдлаар зохицуулалт хийхгүйгээр бид нар нэгэнт гуйлгын, дайврын шинж чанартай явах юм бол хэзээ ч бид нар төсвөө томоохон хэмжээгээр бүрдүүлж чадахгүй. Магадгүй энэ дээр саналууд орж ирээд бид нарт тодорхой мэдээллүүд, санал өгөөд тэрийг нь цааш нь аваад явах боломжууд байсан болов уу гэж бодож байсан. Тоон мэдээлэл бол хангалттай бид нарт байна. Энэ цаасан дээр ч байна. Иймэрхүү байдал дээр манай холбогдох байгууллагууд ажиллаач гэж хүсмээр байна.

Магадгүй тэр хуулийн төсөл дээрээ тодорхой тоо тавьдаг ч юм уу. Ингэж байж одоо энэ процесс нь үр дүнтэй болох санхүүжилтийн асуудал нь шийдэгдэх цаашлаад бидний хамтын ажиллагааны үр дүн гарах нөхцөлүүд бүрдэнэ. Тэгэхдээ бид нар зөвхөн одоогийн бүтцийг нэг хараад үзээрэй. Одоогийн бүтэц чинь яг тэгээд нийгэмших чиглэл рүү яг тэр асуудал гарч байгаа цэг өвчнөө дарж оношлоод эдгээх чиглэл дээр хүрч ажиллаж чадахгүй шүү. Оношоо тогтоогоод, өвчнөө илаарьшуулах алхмыг хийхэд ямар бүтэц хэрэгтэй, ямар зохион байгуулалт хэрэгтэй гэдгийг тодорхой болгож зураглах хэрэгтэй. Бид тэгж байж энэ ажил чинь цаашаа явна. Тэгэхгүйгээр одоогийнхоо бүтцээр баахан юмны дайвар болчихсон, нөгөө орон нутгийн баг болгон дээр байдаг хамтарсан баг гээд явдаг. Тэр чинь хажуугаар нь нөгөө төрийн бүхий л ажлууд явж байдаг. Тэр хүмүүсийн чинь нуруун дээр ийм хавсарга хэлбэрээр яваад ямар ч үр дүн гарахгүй. Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг тооцож бодож төлөвлөж зохион байгуулалтад оруулах хэрэгтэй гэдэг саналыг хэлье. Баярлалаа.

Б.Жаргалмаа - Д.Батлут гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт заасны дагуу оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч гишүүн бусад оролцогчоос асуулт асуухгүй бөгөөд Нийтийн сонсголын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ гэж заасан байгаа тул Байнгын хорооноос сонсголд оролцохоор бүртгүүлсэн иргэн, төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн зарим асуултыг сонсгол даргалагчийн хувиар асууя.

Асуулт хүргүүлсэн иргэн А.Жавхлантөгс “шийтгэл” гэх үг нь Монгол хэлний журамласан тайлбарт “ял торгууль”, “хэрэг хийсэн хүн тухайн гэмт үйлдэлд нь тохируулан өгөх” гэж тодорхойлсон байна.

Шийтгэл нь эрх бүхий байгууллагаас гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэж шийтгэл оногдуулдаг. Тэгвэл хууль тогтоогчид “шийтгэл” гэх үгийг хуульд оруулахдаа ямар утгаар, саналаар хэрэглэнэ гэж оруулсан байдаг юм бэ гэдэг асуултыг ирүүлсэн байна.

ХНХЯ, ХЗДХЯ хариулах уу?

Хүүхдийн эрхийг хамрах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн бие махбодын шийтгэл гэж хууль тогтоогчид баталсан байдаг. Энэ “шийтгэл” гэдэг үгийг ямар утгаар хэрэглэсэн байдаг вэ? Тайлбарлаж өгнө үү гэсэн байна.

Э.Энх-Эрдэнэ – ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Э.Энх-Эрдэнэ байна. Манай Хууль зүйн бодлогын газраас бол хууль тогтоомжийг боловсруулдаг. Би бол хэрэгжилтийг хариуцдаг. Гэхдээ би өөрийнхөө саналыг хэлье.

“Бие махбодын шийтгэл” гэж захиргааны зөрчлийн болон эрүүгийн хариуцлагын хууль дээр л явагдаж байгаа. “Бие махбодын шийтгэл” гэдэг дээр хууль тогтоогчид ямар үзэл баримтлалаар энэ хууль тогтоомжид тусгагдсан асуудлаар хариулах боломжгүй.

“Шийтгэл” гэдэг чинь хүчирхийллийн хэлбэр харин эрүүгийн хариуцлага бол өөр. Шийтгэл гэдэг үгээр хууль зүйн талаас нь тайлбар өгөх болов уу?

Б.Жаргалмаа - ХНХЯ-аас тайлбар өгөх үү?

С.Энхтуяа - Хүүхдийн эрхийн судлаач С.Энхтуяа байна. Энэ *corporate punishment* гэдэг үг маань бие махбодын шийтгэл гээд Монгол хэл рүү буулгачихсан байгаа юм. Ер нь *punishment* гэдэг. Гэхдээ хүүхдийн асуудлаар яагаад орсон юм бэ гэвэл Хүүхдийн эрхийн конвенцод хүүхдийг ямар нэгэн байдлаар буруу зүйл хийснийх нь төлөө зодож, арга хэмжээ авч болохгүй гэсэн үг. Ерөнхийдөө *punishment* гэдэг үгний цаана хүүхдийг бие махбодын хувьд зодож болохгүй л гэсэн санаа явж байгаа. Олон улсын хэмжээнд *corporate punishment* гэж явдаг. Тэгээд хүүхэд хамгааллын хуулийг батлуулахдаа бид нар энийг ярилцаад, Монгол Улс бол олон улсын хэмжээний хүүхдийн эрхийг хамгаалах ойлголтыг хуульдаа нэвтрүүлэх ёстой гэж үзсэн. Ингэснээрээ Монгол Улс нь хүүхдийн бие махбодын шийтгэлийг хориглосон. Азидаа 1 дүгээр улс, дэлхийн хэмжээнд 47 дугаар улс болсон байдаг. Энэ бол маш чухал заалт. Ерөнхийдөө хуулийн хувьд бол яг шийтгэл санц гэсэн утга биш хүүхдийг зодож ямар нэгэн байдлаар тэр хүүхдэд анхааруулга өгөхгүй гэсэн санаа.

Б.Жаргалмаа - Танд баярлалаа. Монголын Саран ээж нийгэмлэгийн ерөнхий менежер Т.Бат-Очир гэдэг хүнээс асуулт ирсэн байна. Холбогдох албаныхан асуултыг нь сайн сонсоорой.

1.Монголын хүүхдийн төлөө сангийн шугамаар хүүхдийн төлөө хөрөнгө хуримтлуулах хөдөлмөрийн баатруудын нэрэмжит хөдөлмөрийн сайн дурын өдрийг бий болгох санаачилгыг яах вэ?

2.Сурагчдын хөдөлмөр амралтын зуслангийн дүрэм, журам, зааврыг аль яам гаргах ёстой вэ?.

3.Хүүхдийг шагнаж урамшуулах ямар бодлого чиглэл байна вэ?

4.Хүүхдийн гэх тодотголтой үрэн таран болсон 100 гаруй барилга байгууламж, зуслангийн асуудлыг хэрхэн шийдэх вэ?

5.Энэ талаар сүүлийн 14 жил Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхий сайд Монголын хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн даргад удаа дараалан тавьсан миний 23 санал бүхий 100 гаруй хуудас захидлын хариуг албан ёсоор өгөлгүй өдий хүрснийг юу гэж ойлгох вэ?

6.Монголын хүүхдийн байгууллагын 100 жилийн ойг хэрхэн хийх вэ? гэсэн байна.

Н.Баярмаа - Т.Бат-Очир гуайн маань манай хүүхдийн байгууллагын ахмад зүтгэлтэн байгаа. Хүүхдийн төлөө фондыг сэргээн байгуулах яг энэ асуудлыг 2016 оноос хойш тавьж явсан. 2020 онд бид Хүүхдийн эрхийн тухай хууль, Засгийн Газрын тусгай санд нэмэлт, өөрчлөлт оруулж “Хүүхдийн төлөө сан”-тай болсон байгаа. Энэ сангийн зохицуулалтаар бол улс, тив, дэлхийн уралдаанд амжилт гаргасан хүүхдүүдийг урамшуулах, нөгөө талдаа бол энэ уралдаан тэмцээнд оролцохоор болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх гэсэн зохицуулалтаар Хүүхдийн төлөөх фонд ажиллаж байна. Одоогийн байдлаар бол улсын хүүхдийн төлөө санд 11,1 тэрбум төгрөг төвлөрсөн. Энэ төвлөрснөөс эхний байдлаар бол 1 тэрбум орчим төгрөгийг нь бүтээн байгуулалт болон олон улсын уралдаан тэмцээнд оролцсон хүүхдүүдийн урамшуулал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дэмжлэгт зарцуулчихсан, заримыг нь зарцуулахаар төлөвлөөд ажиллаж байна. Хүүхдийн хөдөлмөр зуслангийн асуудлаар Т.Бат-Очир гуай манай ажлын хэсэгт байнга ажилладаг.

Энэ оны 5 сард бид хүүхдийн зуслангийн нийтлэг шаардлага стандартыг шинэчлээд хүүхдэд хөдөлмөрийн дадал олгох амьдрах ухааны зуслан хэрэгжүүлэх талаар зуслангийн стандарт батлагдчихсан байгаа. Өчигдөр яг эцсийн байдлаар Үндэсний стандартчилал, хэмжил зүйн газар дээр баталгаажилтаа аваад 2023 оны стандарт батлагдсан байгаа. Харин хөдөлмөр зусланг хэрэгжүүлэхтэй холбогдуулж зусланг ихэвчлэн сургуулиудын дэргэд, сум, орон нутгийн Засаг даргын дэргэд байгуулж байгаа. Тэгэхээр бид хөдөлмөр зусланг стандартдаа нийцүүлээд ажиллуулах байгууллага маань стандартынхаа дагуу зуслангийнхаа журам, дүрмийг нь батлаад явах ийм зохицуулалттай байгаа гэдгийг хэлье. Хүүхдийн төлөө байгууллагын ахмадуудтай болон хүүхдийн төлөө ажилладаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй Ерөнхий сайд сая уулзсан. Т.Бат-Очир гуай ч гэсэн уулзсан байгаа. Үүнтэй холбогдуулаад Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг бас шинэчлэн зохион байгуулъя, шинэчлэн зохион байгуулах ажил дээр бас иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй, цоо шинэ бүтэцтэйгээр ажиллая гэсэн байгаа.

Энэ асуудал дээр бол бид Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлээд байна. Үнэхээр үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг гишүүнчлэлтэй сүлжээ байгууллагаа төлөвлөсөн. Одоо иргэний нийгмийн байгууллагууд маань бас энэ үндэсний зөвлөлдөө ороод ажиллах болов уу гэсэн ийм төлөвлөлтийг хийгээд байж байна. Ерөнхий сайд бас чиглэл өгсөн.

Монгол Улсад хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг

тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг тусгайлан Засгийн газрын түвшинд байгуулна. Энэ дээр 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг төлөвлөлттэйгөөр ажиллана гэсэн байгаа. Тэгээд бид нар Хүүхдийн төлөөх үндэсний зөвлөлийн хурлаар бас энэ ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг оруулж та бүхнийхээ саналыг авч ажиллана гэж хэлье.

Б.Жаргалмаа - Н.Баярмаа дарга аа. Хүүхдийн 100 гаруй барилга байгууламж алга болсон гэж байна. Энэ дээр та тайлбар хэлээрэй.

Н.Баярмаа - Саран ээж нийгэмлэгээс яг энэ асуудлыг гаргаж байсан. 2012 онд Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яам байхдаа бас энэ судалгаануудыг хийсэн. Тэгээд 2020 онд Засгийн газраас ажлын хэсэг гаргаж А зэрэглэлийн, Б зэрэглэлийн гээд энэ асуудлууд дээр холбогдуулаад газар олголтыг шийдэх чиглэл өгөөд явж байгаа.

Өнгөрсөн жил бид нар бас яг энэ асуудал дээр хүүхдийн байгууллагын хэчнээн барилга байгууламж байна вэ гэдгийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Монголын зуслангуудын холбоотой хамтраад судалгаа хийж, үнэлгээ дүгнэлтийг гаргачихсан. Сая хүүхдийн байгууллагуудтай уулзсан. Уулзалтын хүрээнд хүүхдийн зуслангийн менежментийн хувьчлалд орсон 10 хэдэн зуслангуудын асуудлууд дээр хяналт шалгалт хийж, аудит хийгээч гэсэн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдаас Үндэсний аудитын газарт хандаж хөндлөнгийн аудит хийлгэх хүсэлтийг тавьчихсан байгаа.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар дээр 2012 оноос хойших хийгдсэн судалгаа, барилга байгууламжуудын жагсаалтыг Аудитын газар ирүүлээч гэсэн хариу ирсэн байгаа. Тэгэхээр Үндэсний Аудитын газартай мөн Төрийн өмчийн хороотой хамтран хөндлөнгийн аудит хийх ажлууд нь явагдана гэж үзэж байгаа.

Б.Жаргалмаа - Өөрт байгаа мэдээллээ ерөнхий менежер Т.Бат-Очир ахад өгье. Хүүхэд залуучуудын театрын барилга бол 95%-ийн гүйцэтгэлтэйгээр Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороонд баригдаж байгаа. Төлөвлөснөөр 9 сарын 1-нд нээлтээ хийнэ. Соёлын яамнаас өнөөдөр бас төлөөлөл байх ёстой. Ирээгүй байна. Хүүхдийн номын сан болон Хүүхэддэйн театрын барилгын хувьд Чингэлтэй дүүргийн Тасганы овоонд газар олголт явагдсан боловч яг өнөөдрийн байдлаар бас бүтээн байгуулалтын ажил эхлээгүй байдалтай л явж байгаа. Төв номын сангийн ажил бол 95%-ийн гүйцэтгэлтэй гүйцэтгэгч компани дээр асуудал үүссэн учраас гацалттай. Гэхдээ ер нь энэ ондоо багтаан Улсын комисст хүлээлгэн өгнө гэсэн. Ийм байдалтайгаар явагдаж байгааг танд дуулгая.

Гуравдугаар асуултыг Монголын сургуулийн нийгмийн ажилтны холбоо Төрийн бус байгууллагын тэргүүн Б.Мөнхжаргалаас ирүүлсэн байна. Хүүхэд хамгааллын 8 тэрбумын зардлаас боловсролын салбарт хэдэн төгрөг зарцуулсан бэ? (*Завсардалт, архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн бэлгийн дарамтад өртсөн охидод гэх мэт*) Энэ асуудалд зарцуулагддаг уу, үгүй юү гэсэн

ийм асуулт байна. Энэ дээр тайлбар авъя.

Н.Өлзийхутаг - Хүүхэд хамгааллын 8 тэрбум төгрөг маань үндсэндээ аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хэлтэс гээд 30 байгууллага, дээр нь харьяа 5 байгууллагад хамтарсан багийг дэмжих зардал, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний зардал гээд 30 гаруй чиглэлд 8 тэрбум төгрөг маань зарцуулагдаж, хуваарилагдаж явдаг байгаа. Нэг аймагт 70-250 орчим сая төгрөг төсөвлөн аймаг бүрд урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил, хамгаалах, нөхөн сэргээх зардал шуурхай тусламжийн үйлчилгээ гээд хуваарилдаг.

Ингээд 3 түвшиндээ үйлчилгээний зардал маань хуваагддаг. Энэ жилийн хувьд бид төсвийнхөө 75%-ийг орон нутагтаа хуваарилсан, 20 орчим хувь нь агентлаг дээрээ ийм л байдлаар төсвөө хуваарилсан байгаа.

Б.Жаргалмаа - Баярлалаа. Хуралдаанд ирүүлсэн зарим асуултын хариултыг холбогдох албаныхнаас авч дууслаа. Хуралдаан даргалж байгаагийн хувиар би нэг зүйл тодруулъя.

Ламхай нартай холбоотой асуудал үүссэн, энэ асуудлаар ер нь ямар ажил хийж байна вэ гэдэг олон асуултыг нийгмийн зүгээс тавьсан. Яг өнөөдрийн байдлаар энэ асуудал ямар шатандаа явж байна? Шүүх шинжилгээний дүгнэлт гарсан гэдэг ийм мэдээллийг өгсөн байгаа. Бид Гандантэгчэнлин хийдтэй хэрэг гарсан, асуудал үүссэн тэр цаг мөчөөс холбогдож мэдээллийг авч байна. Яг өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллагаас албан ёсоор мэдээлэл ирүүлээгүй байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хийсэн хяналт шалгалтын хүрээнд хүүхэд хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлэх үйл явцтай байгаагаас гадна дотуур байранд тавигдах стандарт шаардлагын дагуу хүүхэд хөгжүүлэх өрөө дотуур байрны орчны үнэлгээ хийгдэж байна. Холбогдогч хүүхдүүд болон эцэг эх рүү чиглэсэн холбон зуучлах ажлыг Баянгол дүүргийн Хүүхэд хөгжлийн газар хийж байна гэдэг ийм мэдээллийг Гандантэгчэнлин хийдээс ирүүлсэн байна.

Миний дараагийн асуулт хүүхдээ хамгаалуулах гээд өөрсдөө хүүхдийнхээ эрхийг зөрчсөн нөхцөл байдал үүссэн байгаа. Бидэнд стандарт байна уу, үгүй юу гэдэг зүйлийг асууя. Өөрөөр хэлэх юм бол хүүхэд хамгаалах түр байран дээр байнгын хорооноос ажлын хэсэг гарч ажилласан байгаа. Нэг өрөөнд хамгаалалт хүсэж байгаа хүүхдүүд маань маш олноороо байрлаж байгаа. Эргээд эцэг эхчүүдтэй холбогдох, гадаад орчинтой холбогдох ийм боломж байхгүй байна гэдэг ийм асуудал үүсэж байсан. Өөрөөр хэлбэл бид хүүхдээ хамгаалуулахдаа өөрсдөө хүүхдийнхээ эрхийг зөрчөөд, энэ нөхцөл байдлыг үүсгэсэн байсан. Энэ дээр арга хэмжээ авсан уу, үгүй юу? Ер нь энэ мэт нөхцөл байдал дээр бодит ажлыг бид юу хаана хийх ёстой юм бэ? Энэ асуудал өнөөдөр ямар нэгэн байдлаар яригдсангүй.

Нөгөө талаар сүүлийн үед өсвөр насны жирэмслэлт маш их хэмжээнд байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвүүдийн хүүхдийн кабинетууд хангалттай ажиллаж чадахгүй байна. Өсвөр насны чиглэлээр эмч алга. Сонгинохайрхан дүүргийн эмч нар маань бидэнд мэдээлэл ирүүлэхдээ 10 өсвөр насны жирэмслэлт орж ирж байхад 3 нь хүчирхийллийн улмаас, 7 нь сайн дураараа жирэмсэлсэн гэсэн ийм тоо хэлж байна. Энэ дээр анхаарч ажиллаач. Бид өсвөрийн хүүхдийн кабинетаа зохих хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байна. Энэ дээр Эрүүл мэндийн яам болон ХНХЯ хариулт өгөхгүй юу?

ЦЕГ-аас Гандантэгчэнлин хийдэд болсон асуудалтай холбогдуулан тайлбар хэлэх үү?

Г.Мөнхбаяр - Тэгэхээр 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр олон нийтийн сүлжээнд Гандантэгчэнлин хийдэд насанд хүрээгүй хүүхдүүдийн хүчирхийллийн талаарх мэдээлэл явсан. Үүний мөрөөр Баянгол дүүргийн цагдаагийн байгууллагаас холбогдох шалгалтын ажиллагааг зохион байгуулсан.

Улсын Ерөнхий Прокурорын баталсан харьяалал тогтоох тушаалын дагуу Мөрдөн байцаах албаны Хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, мөрдөн шалгах хэлтэст 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдөр харьяалал тогтоочихсон.

Ингээд Мөрдөн байцаах албанаас холбогдох шалгалтын ажиллагааг явуулсан. Шүүхийн шинжилгээний ерөнхий газарт дүгнэлт гаргуулахаар холбогдогч болон хохирогч хүүхдүүд дээр нийтдээ 5 хүүхэд дээр дүгнэлт гаргуулахаар тогтоол үйлдээд дүгнэлтээ авчихсан. Одоо мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байгаа. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-т заасны дагуу прокурорын мэдээлж болно гэсний дараа зөвшөөрөгдсөн хэмжээнд холбогдох мэдээллийг иргэд, олон нийтэд цахим орчинд яг мэдээлэл авъя гэсэн телевиз, сайтуудад мэдээллийг өгчихсөн.

Тус хэрэгтэй холбогдуулан Мөрдөн байцаах албанаас тусгай ажлын баг гаргаад 7 дугаар сарын 25-ны дотор шийдвэрлүүлэхээр тухайн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Б.Жаргалмаа - Н.Өлзийхутаг дарга хариулъя.

Н.Өлзийхутаг - Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас яг 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр гарсан Гандантэгчэнлин хийдэд шавилан суудаг хөвгүүдийн дунд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байх магадлалтай юм гэсэн мэдээлэл гарсан. Энэ дагуу Баянгол дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс хамтарсан багтайгаа хамтраад хүүхдийн эрхийн улсын байцаагч оролцон дотуур байранд хяналт шалгалт хийсэн.

Бид хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж өнөөдрийн байдлаар Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн хамгаалах байранд 2 хүүхэд байна. Мөн эхний хохирогч байх магадлалтай хүүхдийн хувьд Баянгол дүүргийн хамгаалах байранд ээжтэйгээ хамт байсан. Ээж нь хамгаалах байрнаас одоогоор түр

гарчихсан байгаа.

Дотуур байранд хяналт шалгалт хийсэн хүүхдийн эрхийн улсын байцаагч албан шаардлагаа хүргүүлсэн. Мөн зохих хууль журмын дагуу торгуулийн арга хэмжээ авч энэ асуудлыг шийдвэрлэсэн. Хүүхдийг сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулж, өмгөөллийн зардлыг хүүхэд хамгааллын зардлаас гаргаад 3 хүүхдэд бид өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна. Хүүхдүүдийг өрхийн эмч болон Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв буюу бид нарын ярьж заншсанаар Эх нялхсын төвд үзүүлж, эмчилгээ хийлгэсэн. Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд үзүүлж оношилгоо хийлгэсэн. Одоо гэр бүлдээ байгаа хүүхдүүдэд эргэж хяналт тавьж ажиллаж байна.

Б.Жаргалмаа - Эрүүл мэндийн яамнаас хариулъя.

Ө.Энхмаа - Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламж үйлчилгээний хүүхэд, өсвөр үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний асуудал хариуцсан ахлах шинжээч Ө.Энхмаа байна. Улсын хэмжээнд өсвөр үеийн нийтдээ 34 кабинет ажиллаж байгаа. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв дээр Өсвөр үеийн клиник үйл ажиллагаагаа явуулж байна. 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт өсвөр үеийн кабинет үйл ажиллагаагаа явуулж байгаа. Өсвөр үеийн кабинетын үйл ажиллагаа болон саяын асуусан асуулт бол үнэхээр анхаарал татсан асуудал байгаа. Коронавируст халдварын цар тахал гарсантай холбоотойгоор, мөн эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилт хэрэгжиж байгаатай холбоотойгоор өсвөр үеийн кабинетын үйл ажиллагаа нэлээдгүй доголдож ирсэн байгаа.

Учир шалтгаан нь юу вэ гэвэл Коронавируст халдварын цар тахлын үед өсвөр үеийн кабинетыг харьцангуй ачаалал багатай гэдэг байдлаар хааж эмч нарыг нь Коронавируст халдварын цар тахлын үйл ажиллагаанд татан оруулсантай холбоотойгоор зарим кабинетын үйл ажиллагаа доголдсон байгаа. Мөн гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой эмч мэргэжилтнүүдийг дутагдалтай учир зарим үйл ажиллагаа доголдолд ороод явж байна. Энэ талаар Эрүүл мэндийн яам зохих үнэлгээ, дүгнэлт өгөөд 2021-2022 онд эрүүл мэндийн салбарт өсвөр үеийн кабинетын дэмжлэгт удирдлага чиглэлээр 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2022 онд 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулаад өсвөр үеийн кабинетыг хэрхэн яаж ажиллуулах вэ гэдэг зөвлөмжийг боловсруулаад эрүүл мэндийн газрын дарга нарт хүргүүлээд, хэрэгжилтийн тайланг авч, хяналт тавиад ажиллаж байгаа.

Б.Жаргалмаа - Танд баярлалаа. Өчигдөр бас Байнгын хороон дээр Эрүүл мэндийн сайд С.Чинзориг энэ талаар тодруулахад өсвөр үеийн кабинет бол хангалттай ажиллаж байгаа гэдэг мэдээллийг Эрүүл мэндийн яамны Газрын дарга С.Төгсдэлгэр өгч байсан. Тэгээд мэдээлэл зөрж байна.

Нөхцөл байдлыг харах юм бол ер нь хүүхдүүддээ хүрч ажиллах өсвөр үеийнхний эмч мэргэжилтнүүд хомсдолтой байгаа гэдэг нь бол харагдаж байгаа

учраас би таны мэдээлэлд итгэлтэй байна гэдгийг хэлье. Тэгэхээр энэ дээр зайлшгүй арга хэмжээ авах шаардлага байгаа юм байна.

Асуулт асууж дууслаа, Улсын Их Хурлын гишүүд 5 минутад багтаан үг хэлж болно. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

П.Анужин - Өнөөдрийн хяналтын сонсголоор бид ерөнхийдөө мэдээлэл солилцох маягтай боллоо. Ер нь Төрийн ордонд зохион байгуулж байгаа төрөл бүрийн сонсголд би ихээхэн шүүмжлэлтэй ханддаг хүмүүсийн нэг. Хэлбэр төдий 2 талынхаа мэдээллийг сонсдог. Мэдээллийг бол цаасан дээрээс уншиж байна. Тэгээд шийдэл, бодлого маш бага ярьдаг ийм хурал, сонсголууд их бол болдог.

Би түрүүн үгэндээ хэлсэн. Ер нь Монгол Улс энэ хүний хөгжил, хүний ухамсар, ард иргэдээ хоморголон соён гэгээрүүлж хүний энэ төлөв төвшин зан байдлыг нийгэм нийтэд нь төлөвшүүлэх энэ ажил дээр онцгой анхаарах цаг нь болсон. Тэгэхдээ үүний хөшүүрэг нь сайн хөтөлбөр гэхээсээ илүүтэй хүн бүр л дор бүрнээ бие биедээ нөлөөлж, хичээж байж нийгмийн эд эс бүр шинэчлэн сайжрагдах явдал гэж боддог. Гэхдээ үүний цаана нөлөөлж байгаа хүчин зүйлүүд бий. Амь, амьжиргааны тааруухан байдал, цалингийн асуудлууд, архидалт гээд олон зүйлүүд байгаа. Энэ нэг өдөр засрахгүй нь мэдээж. Тэгэхээр бид хууль, эрх зүйн орчин дээр зайлшгүй ялангуяа, Улсын Их Хуралд ажиллаж байгаа гишүүд анхаарч ажиллах шаардлагатай гэж бодож байгаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны зүгээс бид 20-оод хоногийн өмнө ХНХЯ дээр очиж Хүүхэд хамгааллын хуулийн явц хэрхэн явагдаж байгаа, үзэл баримтлал нь хэрхэн боловсруулагдаж байгаа талаар танилцсан байгаа. Гэр бүлийн хуулийг ХЗДХЯ манлайлж боловсруулж байгаа. Бид үзэл баримтлалтай нь танилцсан байгаа.

Эдгээр хуулиудыг Монгол Улсын Засгийн газрын зүгээс яаралтай нягт боловсруулж, цаг үеийн хэрэгцээ шаардлага хууль зүйн хүрээнд нь сайжруулах ийм зайлшгүй шаардлага байгаа учраас эдгээр хуулиудыг Нийгмийн бодлогын байнгын хорооны зүгээс намрын ээлжит чуулган гэхэд Засгийн газрын зүгээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлээч гэдэг шаардлагыг тавьж бас ажиллаж байгаа. Ерөнхий үзэл баримтлалтай нь эмэгтэй гишүүд очиж танилцсан.

Хоёрдугаарт нь Улсын Их Хурлын ирэх намрын чуулганд Нийгмийн бодлогын байнгын хороо хүүхэдтэй холбоотой, хүүхдийн эрх зөрчигдсөн гэмт хэргүүдийн ялын бодлогыг чангатгах тал дээр ер нь гарц гаргалгаа нь юу байна вэ? гэдэг талаар бид томоохон хэмжээний хэлэлцүүлэг хийж, нийгмийн бүхий л төлөөллүүд, хүүхдийн төлөө ажилладаг байгууллагуудтай хамтарч хийхээр төлөвлөөд байна.

Эцэст нь хэлэхэд хүүхдийн эрхийн асуудал гэдэг бол эмэгтэй л хүний анхаарах ажил биш юм. Энэ бол нийгмийн бүхий л шат давхарга хамгийн түрүүнд тухайн хүүхдийг гаргасан ээж аав, цагаа хамгийн ихээр өнгөрөөж байгаа сургууль, цэцэрлэгийн орчин, нөхөрлөж байгаа найз нөхөд, тэднийг хамгаалах бодлогыг

боловсруулж байгаа төр засаг гээд оролцохгүй өөрөөсөө холдуулах ийм нийгмийн нэг ч төлөөлөл байхгүй гэж үздэг.

Тийм учраас хүүхдийн асуудал гарахад бид нар буруутныг хайж араас нь хөөж, чичлэх хэмжээнд дуусгахдаа биш, оюун санаанд суурилсан ухамсрын өөрчлөлтөд суурилсан сайн хуультай ийм нийгмийг бий болгохын төлөө өнөөдрөөс эхлээд бүх хүмүүс анхаарах шаардлагатай ийм л эмзэг асуудал гэж бодож байна.

Шидтэн биш учраас эдгээр асуудлууд нэг өдөр сайжрахгүй нь мэдээж. Тэгэхдээ энэ хөрсийг сайжруулахын төлөө бүхий л нийгмийн төлөөллүүд ажиллах ёстой гэсэн ийм байр суурьтай байна.

Б.Жаргалмаа - Үгээ хэлсэн Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин танд баярлалаа.

Ц.Сандаг-Очир - Хүүхдийн эрхийн асуудал өөрөө зөрчлийн асуудал, маш том асуудал. Энэ том асуудлыг өнөөдөр энд тэндээс нь нэг талх гээд үзвэл энд тэндээс нь л мэрээд байна. Яг асуудлын голд, яг яах гээд байгаа юм, ямар шийдвэр гаргах гээд байгаа юм гээд. Ингэхээр их бүрхэг харагдаад байна. Тийм учраас цаашдаа ийм хурал уулзалтуудын үр өгөөжийг бодоод би бас Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, хуралдаан даргалагч нараас юу хүсэх гээд байна вэ гэвэл тодорхой нэг сэдвээр асуудлыг нэг нэгээр нь ярья. Тухайн асуудалтай холбоотой, холбогдох хүмүүсийг нь байлцуулъя. Яг тухайн асуудалтай холбоотой байгууллагуудыг нь оролцуулаад яг тэр асуудлаар нь тусгайлан авч хэлэлцээд тодорхой нэг шийдвэр гаргаад явъя гэдэг байдлаар. Эсвэл зөвхөн төсвийн хүрэлцээ хангамжийн асуудлаар, төсөв мөнгө ирэх жилийн төсөв батлагдахтай холбогдуулаад ч гэдэг юм уу, бүтэц орон тооны байдал, ажлын уялдаа холбооны асуудлаар ярилцъя ч гэдэг юм уу, ярилцаад шийдэл гаргаад явъя. Ингээд яг тодорхой асуудлыг магадгүй сар болгон нэг хуралддаг өдөртэй болоод тэгээд жилдээ 12 хуралдаад 12 асуудлыг 100% гэдэггүй юм гэхэд тодорхой үр дүн, шийдвэр гаргаад жилийн эцэст үзэхээр бид нар 12 удаа хуралдсан байна 10 дээр нь ийм асуудал ярилцаад ийм үр дүн гарсан байна тодорхой. Ийм 10 асуудал дээр бид нар бас нэг амжилт үр дүн тодорхой хэмжээнд гарчихсан байна. 10 асуудлыг бас тодорхой хэмжээнд шийдсэн байна шүү гэдэг. Энэ магадгүй сар болгоны хэд дэх 7 хоногийн ч гэдэг юм уу. Тэд дэх өдөр нь Нийгмийн бодлогын байнгын хороон дээр яг энэ асуудлаар магадгүй жилийн эхэндээ ч гэдэг юм уу улиралд гэдэг юм уу, хэлэлцэх асуудлын дараалал, товыг бүүр батлаад, холбогдох байгууллагууд нь хуваарийн дагуу мэдээллүүдээ бэлтгээд, гишүүд бас тодорхой мэдээлэлтэй орж ирээд ингээд явбал цаашдаа энэ уулзалт, хурлуудын үр дүн нь ач холбогдол нь илүү юм болов уу гэж би хувьдаа харж байна.

Түүнээс хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар ярина гэхээр чинь маш өргөн хүрээтэй асуудал байгаа шүү дээ. Энд тэндээс нь яриад л оочин цоочин алаг цог яриад ингээд ерөөсөө үр дүнд харагдахгүй байна. Ерөөсөө үр дүнтэй байя гэвэл нэг тиймэрхүү байдлаар шийдвэрлэх шаардлагатай гэсэн санал хэлж байна. Та бүхэн тунгаана биз. Баярлалаа.

Б.Жаргалмаа - Ц.Сандаг-Очир гишүүндээ баярлалаа. Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр тогтоол гаргахдаа Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан нарын 9 гишүүнээс ирүүлсэн Хүүхдийн эрхийн тухай хуульд заасны дагуу тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрх, хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, хувийн мэдээлэл, орон байрны халдашгүй байдал хувийн орон зайгаа хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн талаар гээд шууд зүйл заалт нь заагдчихсан энэ сэдвийнхээ хүрээнд л бид нар бас өнөөдрийн хяналтын сонсголыг зохион байгуулж байгаа гэдгийг танд дуулгая.

Бид өнөөдөр Б.Баярсайхан нарын 9 гишүүнээс гаргасан саналын дагуу хяналтын сонсголыг зохион байгууллаа. Сонсголоор илэрсэн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх ямар асуудал байна вэ гэдгийг бид дүгнэх ёстой. Бид хяналтын сонсголоосоо тодорхой хэмжээний дүгнэлт чиглэл гаргаад Нийгмийн бодлогын байнгын хороогоороо хэлэлцүүлээд, Улсын Их Хуралд хэлэлцүүлэх дэгтэй. Энэ дэгийнхээ дагуу бид дүгнэлтээ гаргах болно.

Өнөөдрийн энэ хяналтын сонсголд оролцож үгээ хэлж бас санал бодлоо илэрхийлсэн та бүхэндээ баярлалаа.

Өнөөдрийн хяналтын сонсголыг дүгнэвэл бид хууль зүйн өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлага байгаа юм байна. Хүүхэд хамгааллын асуудлаар ХНХЯ болон ХЗДХЯ Гэр бүлийн тухай хуулиараа, хуулийн шинэчилсэн төслийг өргөн барих гэж байгаа. Сая Байнгын хорооны дарга маань хэллээ. Өнөөдөр үүссэн кэйс тохиолдлуудыг дахин гаргахгүйн тулд яах ёстой юм. Хамтарсан баг маань үйл ажиллагаа явуулахад юу шаардлагатай байгаа, үнэхээр хүний нөөцийн оролцоо дутуу байгаа юм уу, тэгвэл яаж шийдвэрлэх ёстой юм. Төсөв мөнгөний асуудлыг нь хэрхэн яаж тусгах ёстой юм гэх мэт асуудлаар та бүхэн үгээ хэлж саналаа илэрхийллээ. Энэ дээр бид дүгнэлт гаргах зайлшгүй шаардлага байгаа гэдгийг хэлье.

Мөн бид сум, хороонд ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудынхаа чадавхыг нь яаж нэмэгдүүлэх ёстой юм, хүний нөөцийг нь яаж бүрдүүлэх ёстой юм гэдэг эрсдэлийн судалгаа хийсэн. Энэ судалгаанд хамрагдсан хүүхдүүд маань үнэхээр эрсдэлд өртөөд байвал бидний судалгаа бодитой болж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр ч гэсэн дүгнэлт хийх зайлшгүй шаардлага байна гэдгийг өнөөдрийн хяналтын сонсголоос харсан байх гэж бодож байна.

Ийнхүү Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу ажлын 5 өдөртөө сонсголын тайлангаа гаргаад, Байнгын хорооны хуралдаандаа танилцуулан, санал, дүгнэлтээ боловсруулна. Санал дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаандаа танилцуулна.

Шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцээд холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах зөрчлийг арилгуулах зорилгоор Засгийн газар, холбогдох байгууллагад тогтоолоороо чиглэл өгөх юм байна. Цаашлаад Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж, нэгдсэн чуулганы хуралдаанд танилцуулах боломжтой.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүд болон албан тушаалтнууд, иргэд, төрийн байгууллагууд, нийт оролцогчдоо талархлаа илэрхийлье. Та нартаа баярлалаа.

Сонсгол хаасныг мэдэгдье.

ТАНИЛЦСАН:

Улсын Их Хурлын гишүүн,
Сонсгол даргалагч



Б.Жаргалмаа

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:

УИХТГ-ын ХШҮГ-ын
ХШХ-ийн референт



Д.Отгонбаатар